

Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл										
Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар										
2022 оны жилийн эцэс										
Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ										
1	1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл	1.1.1. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох, хүүхэд залууст Цэрэг-эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэн Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх үзлийг дэлгэрүүлнэ.	2021 - 2025	-	Зохион байгуулсан арга хэмжээ	Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох зорилгоор Сээр цохих тэмцээнийг 2 сум явуулж, Мөсөн шагайны 9 хөлгийн харваа Улсын хэмжээний тэмцээнийг Биндэр суманд зохион байгуулж нийт 230 иргэн хамрагдсан. Хүүхэд залуучуудад "Цэрэг-эх оронч" үзэл хүмүүжил олгож төлөвшүүлэх зорилгоор "Цэрэг эх орон"- сэдэвт дууны тэмцээнийг цахимаар зохион байгуулж 32 дуучид оролцсон. Нийт Сургууль цэцэрлэгүүдэд монгол зан үйлийн болон ахмад дайчид алдартнуудыг сурталчлах булан танхим байгуулан ажиллаж байна.	Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох талаар 2 арга хэмжээг зохион байгуулж 5000 -аас доошгүй хүнд хүрч ажилласан.		Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох зорилгоор Хэнтий аймагт "Өв соёл үндэсний бахархал сарын аян", "Ерөөлч магтаалчдын улсын уралдаан", "Буриадын нэг өдөр" өдөрлөг, "Хөөрөгт хөгжмийн улсын уралдаан", Бөх, морь цоллоочдын улсын уралдаан зэргийг амжилттай зохион байгуулж нийт 325 хүн оролцож 37820 хүн хүргэсэн. Түүнчлэн хүүхэд багачуудын дунд "Эх түүхийн жимээр" уралдаант наадам зохион байгуулж 480 хүүхэд оролцсон. Мөн Соёл урлагийн газраас санаачлан үндэсний уламжлалт ёс заншил, эх хэл, бичиг үсэг, үндэсний түүх, эх оронч үзэл төлөвшүүлэх зорилгоор монголчуудын эрхэмлэн дээдлэх 9 үнэт зүйлийг хүүхэд залуучуудад ойлгуулан таниулах сургалт зохион байгуулж 35 соёлын ажилтан, 16 оюутан залуучуудыг хамруулсан. зохион байгуулсан. Иргэдэд соёлын өвийн боловсрол олгох, цахим болон танхимын нийт 26 ажил зохион байгуулж 8154 хүнийг тус тус хамруулсан.	100%

2	1.2. Нүүдлийн соёл иргэншилт Монгол	1.2.1. Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай иргэнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Зохион байгуулсан арга хэмжээ хамрагдсан хүний тоо	Хэнтий урлангийн зураач Монголын урчуудын эвлэлийн гишүүн, Хэнтий аймгийн зураач урчуудын холбооны гишүүн Д.Оюунтамир, Нэгдсэн Эмнэлгийн их эмч "Нандин өв соёл" урлангийн Уран хатгамалч Ж. Эрдэнэсүвд, Хэрлэн сумын 4-р сургуулийн Монгол хэл, Уран Зохиолын багш Э.Эрдэнэсүвдын Галиграф бичгийн өв соёлыг Орон нутгийн Телевизээр болон фэйсбүүк цахим хуудсаар сурталчлан олны хүртээл болгосон. Аймгийн хэмжээнд морин хуур, ардын бүжиг, ардын хөгжим, дууны зэрэг 8 төрлийн дугуйланд нийт 272 иргэн, хүүхэд залуучуудыг хамруулаад байна. 18 сумын соёлын төвүүд нийт 45 өвлөн уламжлагчдыг алдаршуулах ажлыг зохион байгуулж иргэдэд цахимаар сурталчлан 14800 хүнээс хандалт авч монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан.	"Монгол үндэстний уламжлалт соёл болох "Мөсөн шагайн харваа"-г Биндэр, Хэрлэн зэрэг сумдад 1, 2 сард амжилттай зохион байгуулж нийт 85 харваачид оролцсон. Үндэсний сур, Шагайн харвааг үндэсний баяр наадмаар Чингис хотод болон сумдад зохион байгуулж аймгийн хэмжээнд 240 гаруй харваачид оролцсон байна. Мөн "Сээр шалгах" тэмцээнийг аймаг, бүсийн хэмжээнд 10 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 360 гаруй хүн хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд морин хуур, ятга, ёочин, шударга хөгжмийн сургалтад нийт 285 хүүхэд залуучууд хамрагдан, тогтмол хичээллэж байна."		"Монгол үндэстний уламжлалт соёл болох "Мөсөн шагайн харваа"-г Биндэр, Хэрлэн зэрэг сумдад 1, 2 сард амжилттай зохион байгуулж нийт 85 харваачид оролцсон. Үндэсний сур, Шагайн харвааг үндэсний баяр наадмаар Чингис хотод болон сумдад зохион байгуулж аймгийн хэмжээнд 240 гаруй харваачид оролцсон байна. Мөн "Сээр шалгах" тэмцээнийг аймаг, бүсийн хэмжээнд 10 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 360 гаруй хүн хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд морин хуур, ятга, ёочин, шударга хөгжмийн сургалтад нийт 285 хүүхэд залуучууд хамрагдан, тогтмол хичээллэж байна."	100%
---	-------------------------------------	--	-------------	---	--	---	--	--	--	------

3	1.3.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.	2021 - 2025	-	Бүх шатны боловсролын байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа хамрагдсан хүний тоо	Бүх шатны боловсролын байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа хамрагдсан хүний тоо	байгууллага, иргэд, албан хаагч нарт сургалт зохион байгуулан хамрагдагчдын тоог нэмэгдүүлсэн байна.	"Байгууллагаараа Монгол бичигтэн" аянд 7 байгууллага, "Миний Монгол бичиг" үзэсгэлэнд 5 баг, Монгол хэлний ЭЕШ-д 800 оноо авсан 3 сурагч, эх хэлний судлагдахууны хамтарсан баг, масс олимпиад 13, нийт 26 анги, байгууллага хамт олон, 3 сурагч, 5 багшийг 18,0 сая төгрөгөөр урамшууллаа. Мөн Монгол бичгээр албан хэргээ хөтлөн явуулдаг иргэн Ч.Ариунааг МОНТВ-ээр, "Мөнх тэнгэрийн бичиг-2022" уралдаанд амжилттай оролцсон Хэрлэн 1-р сургуулийн сурагч Б.Ичиннорвоог Монгол ТВ-ээр сурталчлан таниулж, олон нийтэд үндэсний бичиг үсгээ сурах, судлах идэвхийг өрнүүлээ.8,2 мянган дагагчтай "Хэний аймгийн Засаг даргын Тамгын газар" пэйж хаягийн мэдээ мэдээллийг монгол бичгээр зэрэгцүүлэн хөтлөхөөс гадна аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайлан, сумдад танилцуулах мэдээллийг үндэсний хос бичгээр хослуулан бичиж, танилцуулж байна. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 18 байгууллагын 452 албан хаагчдад 40 цагийн үндэсний бичгийн сургалтыг зохион байгуулж. Хөтөлбөрийн цагийг дүүргэж амжилттай төгссөн Стандарчлал хэмжил зүйн газрын 13 албан хаагчид 100% хамрагдаж батламж гардууллаа. Төрийн 185 байгууллагын 123 улирдах албан	100%
---	---	-------------	---	--	--	--	---	------

1.3 Монгол хэл бичиг

4	1.3. Монгол хэл, бичиг	1.3.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.	2021 - 2025	-	Зохион байгуулсан арга хэмжээ хамрагдсан хүний тоо	Насан туршийн боловсрол төвийн багш нараар дамжуулан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн танилцуулга сургалтыг 350 хүнд цахимаар хүргэв. Мөн Хэнтий аймгийн 18 сум 5 тосгоны төрийн албан хаагчид орсон 2843 дагагчтай "МОНГОЛ БИЧИГ ХЭНТИЙ АЙМАГ" цахим бүлгэмээр өдөр тутмын мэдээ мэдээлэл, мэндчилгээг монгол бичгээр оруулан ажиллаж байна. Монгол хэл бичгийн албан хэргийн түвшинд зөв хэрэглэх чиглэлээр 25 төрийн байгууллагын бичиг хэрэгт Монгол хэлний зөв бичих зүй болон компьютерт монгол бичгээр бичих сургалт зохион байгууллаа.	төрийн байгууллагын албан хэргийн түвшинд хэрэглэх чиглэлээр сургалт зохион байгуулах хамрагдсан албан хаагчдын тоог нэмэгдүүлэх	Хэвлэмэл хуудас хэвлэх зөвшөөрөлтэй 2 хэвлэлийн газарт MNS:6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудасны эхийг бэлтгэж, хянуулах талаар мэдэгдэл хүргүүлж, нийтлэг хэрэглэгддэг "захирамж, тушаал, албан бичгийн А4, А5" хэвлэмэл хуудасны захиалга хүргүүлсэн боловч Хэвлэлийн газраас бэлтгэн ирүүлсэн хэвлэмэл хуудасны эх загвар нь стандартын шаардлага хангаагүй тул Архивын Ерөнхий газрын Сургалт судалгааны газарт хэвлэмэл хуудасны эхийг дахин хийлгэх хүсэлт хүргүүлээд байна. АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн Архивын тасаг, аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран цахим болон танхим хосолсон хэлбэрээр 153 албан хаагчдад Монгол улсын стандарт MNS 6395:2022-ын танилцуулга, Баримт бичгийн стандартын дагуу зохиож бүрдүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Архивын Ерөнхий газар, Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтран аймгуудын Төрийн архив болон төрийн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтанд цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 107 ажилтан хамрагдсан.	100%
---	------------------------	--	-------------	---	--	--	--	---	------

5	1.4. Дэлхийн Монгол	1.4.1. Орон нутгийн түвшинд үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	Ардын билэг зүйч, ерөөлч магтаалч Л.Агваанжамбалын нэрэмжит "Жонон хонгор" дууны уралдаан, "Амар мэндийн аялгуу теле концерт, "Уран жиргээ-2021" уран уншлагын уралдаан, Гэртээ бүжиглэе чөллөнж зарлан сум бүр өөрсдийн уламжлал, онцлогт тохирсон танхимын болон цахим 76 үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 31295 иргэдийг оролцуулан ажилласан. "Үндэсний сонгодог урлаг-3" дунд хугацааны хөтөлбөрийн 1 дүгээр шатны төлөвлөгөөнд тусгагдсан "Учиртай гурван толгой дуурь"-ийн бэлтгэл ажил хангагдаж туурвихад бэлэн болсон байна. Чингис Хаан дуурийн зохиолыг орон нутгийн төсвөөс 3 сая төгрөгөөр авч бэлтгэл ажил хийгдэж эхэлсэн. ГБХЗХГ-ын дэргэд А.Дөлгөөн багшийн удирдлага дор мөн Бор-Өндөр сумын соёлын төвийн дэргэдэх балет болон сонгодог бүжгийн чиглэлээр нийт 66 хүүхэд хамрагдан хичээллэж байна.	Үндэсний соёл,урлаг зан заншил, ахуйн талаар 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.		Учиртай 3 толгой дуурийг шинэчлэн найруулж орон нутгийн тайзнаа тавьж олны хүртээл болгосон. Мөрөн сумын харьяат Улсын хошой аварга малчин Д.Цагаан-Өвгөн, Өмнөдэлгэр сумын малчин шилдэг өвлөн уламжлагч Н.Найдан нарын нүүдэлчин монголчуудын ахуй өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зан үйлийн холбогдолтой бүтээлч үйлдвэрлэлийг харуулсан бичлэг хийж контент болгон иргэдэд хүргэж 2100 гаруй хүнээс хандалт авсан. Өвлөн уламжлагчийн амьдрал ахуйн онцлогийг харуулж хийсэн бүтээлийг олон түмэнд сурталчилсан үзэсгэлэн гаргаж улс болон олон улсын чанартай уралдаанд амжилттай оролцуулсан. Хэрлэн сумын соёлын төвийн дарга Д.Ганчөдөр Үндэсний соёл урлаг, зан заншил, ахуйн талаар монголын үндэсний олон нийтийн телевиз болон орон нутгийн телевизээр 3 удаа нэвтрүүлэгт орж ярилцлага өгсөн.	100%
<b>2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>										
6		2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	2021 - 2025	-	Хамран сургалтын хувь	"2021-2022 оны хичээлийн жилд 5 настай 1851 хүүхэд байгаагаас 1785 хүүхдийг буюу 96.4 %-ийг СӨБ-ын үйлчилгээнд хамрууллаа. Цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн багш нар танхимын болон зайны сургалтыг хослуулан зохион байгуулж, зайны сургалтад интернет, гар утсаар холбогдох, теле хичээл үзэж байгаа байдалд хяналт тавьж, теле хичээлийн агуулгыг бататгах цахим хичээл, 1 сарын хугацаанд ашиглах цаасан гарын авлагыг бэлтгэж хүргүүлэх зэрэг хэлбэрүүдийг ашиглаж байна."	96%*-д хүргэж		2022-2023 оны хичээлийн жилд 36 цэцэрлэгт 5 настай нийт 1708 хүүхдээс 1674 хүүхэд /98 хувь/ нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан. 2 хувь нь буюу 34 хүүхэд нь манай аймгийн сумдад бүртгэлтэй байгаа боловч, тухай орон нутагтаа амьдрахгүй байгаагаас гадна тэдэнтэй холбогдох боломжгүй байна.Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд үзүүлсэн дүнг үзэхэд СӨБ-ийн сургалтын чанар 78,99 хувьтай байна.	100%

7	2.1. Боловсрол	2.1.2. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангана.	2021 - 2025	-	Үнэлсэн байдал, шагнал урамшууллын хэмжээ	Зөгийн үүр арга хэмжээний хүрээнд МУИС, МУБИС, УАкадеми, тай хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж, нийт багш, удирдах ажилтнуудыг хамруулж, багш мэргэжлийн ур чадварын тасралтгүй хөгжлийг хангаж ажиллалаа. Ингэсний үр дүнд масс сургалтын чанар болон ЭЕШ-д амжилт үзүүлж, дундаж оноо ахиулсан 81 багш, удирдах албан тушаалтныг 30 сая төгрөгөөр шагнасан.	Мэргэжлийн боловсон хүчний хангалтыг 1%-иар нэмэгдүүлэх, "Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлэх	2022 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад эхний жилд – 117 багш, 5 жилд – 73 багш, 10 жилд – 63 багш нийт 253 багш хамрагдлаа. Мэргэжлийн зэрэгтэй багшийн эзлэх хувь өмнөх оноос 12.3%-иар ахисан. Багш нарын ажлын байранд нь цахимаар, орон нутагт танхимаар мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг 15 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1266 багшийг хамруулахаас гадна МУБИС-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд байгалийн ухааны дадлагажигч оюутан авах хүсэлт илгээх зэрэг ажлуудыг зохион байгуулсны үр дүнд СӨБ-ын үндсэн багш 100% /хөгжмийн багш шаардлагатай/буюу өмнөх оноос 1 хувиар, ЕБС-ийн багшийн хангалт 98.3% буюу өмнөх оноос 0.3 хувиар ахисан байна. Чадварлаг багш арга хэмжээний хүрээнд боловсруулсан төлөвлөгөөний биелэлт 98%-тай байна. БШУ-ны яам, БҮТ-тэй хамтарсан "Хэнтий аймгийн суралцагчын сурлагын хоцрогдлыг арилгах хөтөлбөр" боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд хөтөлбөрийн хүрээнд 2 удаа 7 судлагдахууны 315 багш ЭЕШ өгөх 345 сурагчийг хамруулан сургалт зохион байгуулж Хэрлэн сумын ЕБС-ийн 12 дугаар ангийн 400 суралцагчаас ЭЕШ-ын 8 хичээлээр таблетэд суурилсан шалгалтын авч үзэхэд аймгийн дундаж 44.9%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар ахисан үзүүлэлттэй байсан.	100%
8		2.1.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтооно.	2021 - 2025	-	Судалгаа хийгдсэн эсэх	2021 онд Хэрлэн 1 дүгээр сургууль, Бор-Өндөр ЦС-ийн хэв шинжийг өөрчилж, 2 салгахаар төлөвлөж байсан. БШУЯ-аас хэв шинж өөрчлөх чиглэл өгөхөөр яригдаж байгаа тул 2022 онд аймгийн хэмжээний бүх ЕБС дээр чанар, хүн амын тоонд харьцуулан хэв шинж өөрчлөх ажил нэгдсэн бодлогоор хийгдэхээр хүлээгдэж байна.	сургуулиудад судалгаа хийж шаардлагатай сургуулийн хэв шинжийг өөрчилсөн байна	Бор-өндөр сумын Бор-өндөр цогцолбор сургуулийн ангилалд өөрчлөлт оруулан дунд, ахлах ангийн сургалтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-өндөр бага сургуулийг шинээр байгуулах, Дэлгэрхаан сумын Хэрлэнбаян-Улаан тосгоны сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг ерөнхий боловсролын байгууллагатай нэгтгэн сургууль, цэцэрлэгийн цогцолбор болгон өөрчилөхөөр шийдвэр гарсан.2023 ондоо багтаан Хэрлэн лаборатори 1-р сургуулийн хичээлийн 2-р байр /972- хүүхдийн суудалтай/ хэв шинжийг өөрчлөн урлаг, спорт зохион бүтээх чиглэлээр 5-р сургуулийг шинээр байгуулахаар болсон.	100%

9	2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, эрт илрүүлэлтийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын хариу арга хэмжээ, бэлэн байдлыг бэхжүүлнэ.	2021 - 2025	-	Хамрагдалтын хувь, нөөцийн бэлэн байдлын хувь	Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлсэн 41000 гаруй иргэнийг халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгаанд хамруулж, 28250 хүнд НЭМУТ, ЭМЯ-аас бэлтгэн гаргасан 15 гаруй төрлийн зөвлөмж, гарын авлага хүргэсэн. Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 480.5 сая төгрөгийн хувийн хамгаалах хэрэгсэл, эм ариутгалын бодисын нөөцийг 16 нэр төрлөөр бүрдүүлж бүрдүүлснээр аймгийн хэмжээнд нэг удаагийн багаж, хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдал 80%-тай байна.	хүн амын хамрагдалтын хувь 70%, нөөцийн бэлэн байдал 80%		Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын талаар "Коронавируст халдварын Омикрон хувилбараас сэргийлцгээе", "1000-уулаа МЭДЭЭЛЛЭЭ БҮҮСТЛЭЭ" зэрэг 4 удаагийн аян, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 115750 иргэнийг хамруулсан. Дээрх сургалт сурталчилгаанд зорилтот бүлгийн хүн амын 72%-ийг хамруулсан. Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахалд хэрэглэгдэх 6 оношийн бүлгийн нийт 54 нэр төрлийн эм, 16 нэр төрлийн хувийн хамгаалах хэрэгсэл, 5 нэр төрлийн ариутгалын бодисын нөөцөд тасалдал үүсээгүй. Нөөцийн бэлэн байдлын хангалт 83% байна.	100%
10	2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрчимжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.	2021 - 2025	-	Хүн амын хамрагдалтын хувь	Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр 11 төрлийн сургалт, сурталчилгааны ажлыг бүх эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулж, иргэдийг мэдээллээр ханган, цахим хуудсаар дамжуулан инфографик зөвлөмж, шторкийг түгээн давхардсан тоогоор 42800 гаруй хүн буюу зорилтот бүлгийн 76.4% хамрагдсан байна.	57%		Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хүн амын дунд архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, илүүдэл жин, таргалалтаас сэргийлэх, эрүүл зөв хооллолтыг дэмжих, осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр олон нийтийн 32 төрлийн арга хэмжээг 28 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулснаар нийт 42800 гаруй иргэд, зорилтот бүлгийн 65% хамрагдсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрчимжүүлж ажилласнаар хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг 10000 хүнд 1.6, зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 0.4 промилиор тус тус бууруулсан. Мөн аймгийн хэмжээнд ахуйн осол гэмтэлд өртөх эрсдэлийг үнэлэх ажлын хэсэг бүрдүүлэн 616 өрхөд үнэлгээ хийснээр эрсдэл өндөртэй 19 өрхийг тодорхойлж эрсдэлийг арилгах арга хэмжээг авч ажилласан.	100%

11		2021 - 2025		Шийдвэрлэсэн барилга, автомашин, багийн эмчийн унааны тоо	Улсын төсвийн 4.9 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан, Өлзийт, Батширээт сумын эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, ХБУлаан, Өмнөдэлгэр, Биндэр сумын ЭМТ-ийн шинэ барилга, Гурванбаян тосгоны ЭМТ, УАУЭ, НЭмнэлгийн төрөх тасгийн их засварын ажил 86 хувьтай явагдаж байна. УТХО, ОНХСан болон төсөл хөтөлбөрийн 71.1 сая төгрөгийн санхүүжилтээр 3 эрүүл мэндийн байгууллагыг яаралтай тусламжийн авто машинаар, 2 багийн эмчийг унаагаар тус тус хангаж иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.	3 барилга, 2 автомашин, 3 багийн эмчийн унааг шийдвэрлэх		2022 онд Баянхутаг СЭМТөвийн их засвар 300.0 сая төгрөг, Нэгдсэн эмнэлгийн халдвартын эмнэлгийн их засваруудыг 175.3 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэтгэсэн. Мөн УТХОруулалтаар нийт төсөвт өртөг 4.6 тэрбум төгрөгөөр Батноров, Дадал, Галшар, Дархан, Батширээт сумын эрүүл мэндийн төвүүдийн өргөтгөлийн барилгын ажлуудыг "Си Эйч Би Жи" ХХК, "Мандалт Констракшн" ХХК, "Баян төхөмийн хурд", "Виндер Гарден" ХХК, "Төгс Буянт Өргөө" ХХКомпаниуд хийж гүйцэтгэсэн. УТХОруулалтаар 6 ЭМБайгууллагад 382.1 сая төгрөгийн автомашин олгосон. УТХО-р яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангахад зориулж 3.2 тэрбум төгрөг, ОНТөсөл хөтөлбөрөөр 110.4 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг нийлүүлж тоног төхөөрөмжийн хангалтыг 11.2 хувиар нэмэгдүүлсэн.	90%
12	2.2. Эрүүл мэнд	2021 - 2025		Байгууллагын тоогоор	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийг цахимжуулах ажлын хүрээнд ОНТХО, ОНХС-с 41.9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, цахим программ /ehealth/ ашиглалт 90%-тай явагдаж байна. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт киоск машиныг ашиглалтад оруулснаар иргэд үзлэгийн цаг авах болон лабораторийн шинжилгээг хүлээгдэлгүй авах боломж бүрдсэн. Алсын зайн технологийг ашиглан 2, 3 шатлалын эмнэлэгтэй 27 удаа холбогдож, тусламж үйлчилгээний арга зүйн зөвлөгөөг шуурхай авч ажилласан.	2 байгууллагаар нэмэгдүүлсэн байна.		ОНТХО, ОНХС-с нийт 24.4 сая төгрөгийн 14 ширхэг компьютерыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн ЭМТөвд олгосон ба цахим программ хангалт /ehealth/ ашиглалт 75%-тай явагдаж байна. 3 сумын эрүүл мэндийн төв шилэн кабельд холбогдсоноор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй цахимаар холбогдон эмнэлзүйн зөвлөгөө авах боломж бүрдсэн. Алсын зайн технологийг ашиглан аймгийн 2, 3-р шатлалын эмнэлэгтэй Бор-Өндөр нэгдсэн эмнэлэг, АНЭ эх барих яаралтай тусламжийн чиглэлээр 14, мэдрэлийн тусламж үйлчилгээний чиглэлээр 7, сэхээн амьдруулах чиглэлээр 5 удаа тус тус телемедиценээр зөвлөгөө авч цаг алдалгүй яаралтай тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.	100%



13	2.2.5. Орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлж, антибиотикийн хяналтыг сайжруулна.	2021 - 2025	-	Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь	Бор-Өндөр сумын Нэгдсэн эмнэлгийг антибиотик мэдрэг чанарыг тодорхойлоход шаардлагатай 39 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Нийт эмийн сангийн 80 хувьд буюу 39 эмийн сангийн антибиотик олголтод хяналт тавьж, 30 эмийн сангийн зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан. Эмийн бодлогын хэрэгжилт 87%-тай байна.	85		Эмийн бодлогын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, 7 зорилт, 25 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөө батлуулан ажилласан. Уг төлөвлөгөөнд тусгагдсан 25 үйл ажиллагаанаас хэрэгжилт хангалттай 21 арга хэмжээ, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт 86%-тай байна. Мөн орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлэх, сурталчлах ажлын хүрээнд Баян-Адарга суманд 200 орчим эрдэмтэн судлаач оролцсон "Эмийн ургамлын хэрэглээ, тархалт, нөөц, ач холбогдол" сэдэвт ЭШХурал зохион байгуулж, Хэнтий аймгийн ховор ургамлын лавлах, номыг хэвлүүлсэн. Мөн эмч нарын жор бичилтэд хяналт тавьж арга зүйгээр ханган ажилласнаар антибиотик эмийн жор бичилт өмнөх оныхоос 10% буурсан. "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандарт 13.3, 14.3.4, 20.2.1 заалтын дагуу сумдын 10, Хэрлэн сумын 14 эмийн санд шалгалт хийж, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан.	100%
14	2.2.6. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	2021 - 2025	-	Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	"Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр"-ийн хэрэгжилт аймгийн хэмжээнд 80%-тай байна. Тус хөтөлбөрийн хүрээнд сумдын эрүүл мэндийн төвийн эмч нарын 88% нь байраар хангагдаад байна. 2021 онд 50 сая төгрөгийн өртгөөр Галшар эрүүл мэндийн төвийн эмчийн байрны өргөтгөл их засвар хийгдсэн. Эмч мэргэжилтнүүдийн мэргэжил ур чадварыг хөгжүүлэхээр 4 их эмчийг төрөлжсөн мэргэжлээр сургаж байна. "	77%		"Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд зонхилон тохиолдох халдварт ба халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг шинжилгээ, оношилгоог Хоёрдугаар төв эмнэлэгтэй хамтран салбарын эмч, ажилтны 93 хувийг хавдар судлал, эмэгтэйчүүд, мэдрэл, зүрх судас, дүрс оношилгооны нарийн мэргэжлийн эмчийг үзлэгт хамруулсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 82.7%-тай байна. Эмч мэргэжилтнүүдийн мэргэжил ур чадварыг хөгжүүлэхээр 4 их эмчийг үндсэн мэргэжлээр, төрөлжсөн мэргэшлийн сургалтад 6 их эмч, 10 сувилагч тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 6 их эмч, 1 эх баригч тус тус суралцаж мэргэжил ур чадвараа дээшлүүлсэн байна. 2 ажилтанд иж бүрэн 5 ханатай гэр олгосон.	100%

15		2.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.	2021 - 2025	-	Шинээр байгуулагдсан эцэг эхийн зөвлөлийн тоо	2021 онд шинээр 26 эцэг эхийн зөвлөл байгуулагдаж нийт 102 болсон. Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан 6 сэдвийн хүрээнд нийтдээ 112 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 3618 албан хаагчдыг хамруулсан байна. Эцэг эхийн зөвлөлүүдийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор "Би хариуцлагатай аав ээж" аяныг зохион байгуулж 4 төрлийн үйл ажиллагаанд нийт 2930 хүнийг хамруулсан байна. Аймгийн эцэг эхийн зөвлөгөөнийг зохион байгуулж 150 гаруй эцэг эхийг хамруулан хүүхдийн хөгжил, хамгааллын талаар сургалт мэдээлэл өгч, санал асуулга явуулсан. Тус зөвлөгөөнөөс гарсан санал санаачлагыг 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж байна.	шинээр 20-аас доошгүй байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулсан байна		2022 онд шинээр 87 эцэг эхийн зөвлөл байгуулагдаж, нийт 189 төрийн байгууллага, 15 ААНэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлтэй болж, хүүхэд хамгааллын бодлого батласан. Мөн 87 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан ажилласан байна.	100%
16	2.3. Гэр бүл	2.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.	2021 - 2025	-	Ахмадын сантай болсон байгууллагын тоо, хүртээмжийн үнэлгээ хийсэн байгууллагын тоо	2021 онд шинээр ахмадын сан байгуулан ажиллаж байгаа 47 байгууллага байна. Тэргэнцэртэй иргэдийн холбоотой хамтран 48 байгууллагад хүртээмжийн үнэлгээ хийж, үнэлгээний дагуу засаж сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлсэн.	30-аас доошгүй байгууллагад ахмадын сан байгуулж ажиллана.30-аас доошгүй байгууллагад үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн байна.		Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээний ахмадын сангийн данстай байвал зохих 178 байгууллага байдгаас 2022 он гарсаар аймгийн хэмжээний ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв, ЭМТөвийн нийт 103 төсөвт байгууллага улсын төсвийн байгууллага болж хасагдсанаар орон нутгийн нийт 75 байгууллагаас 70 төсөвт байгууллага ахмадын сангийн данстай болж, 93 хувьтай хэрэгжиж байна. Хэнтий аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөгөөний 2.4.7-д тусгагдсан "Тусгай хэрэгцээ шаардлагатай иргэдийн орчны хүртээмжийг сайжруулж, орчин бүрдүүлсэн байгууллага аж ахуй нэгжийн тоог нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд 26 Эрүүл мэндийн байгууллагуудаар хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэн ажилласан.	90%

17	2.3.3. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгаж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	2021 - 2025	-	Хүүхдэд ээлтэй байдлын индекс	Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллалаа. Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай хэрэгжсэн бөгөөд хүүхдэд ээлтэй байдлын индексийг үнэлүүлэхээр судалгааны байгууллагад хүргүүлээд байна.	Хүүхдэд ээлтэй байдлын индекс 1 нэгжээр ахисан байна.		Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлт болон хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж хүүхдэд ээлтэй аймаг болох зорилтын хүрээнд 2022 оныг "Хүүхдийн хөгжил, хамгааллын жил" болгон зарлаж жилийн ажлын төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 90.3 хувьтай үнэлүүлсэн. Хүүхдэд ээлтэй байдлын индексийг хөндлөнгийн хяналтын байгууллага буюу "Хүүхэд эрдэнэ хөгжлийн төв" нийгэмд үйлчлэх ТББ-аар гүйцэтгүүлж 2019 онд 4.9, 2020 онд 5.7, 2021 онд 6.3, 2022 онд 7.3 болж 1 нэгжээр ахисан байна.	100%
18	2.4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана.	2021 - 2025	-	Аюулгүй байдал хангагдаж буй эсэх	Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй нарийн боовны болон бууз баншны 10 үйлдвэр, цехийн хүнсний хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлын талаар шалгаж мэргэшил аргагүйн зөвлөгөө өгч хяналт тавьж ажиллалаа. Хэрлэн сумын 1-10-р цэцэрлэг яслаар Аюулгүй хүнсний сав, Давсны зохистой болон зохисгүй хэрэглээ" талаарх мэдээллийн хуудас бэлтгэн тарааж, хүүхдийн хоол хүнсний хадгалалт, эрүүл ахуйн талаас шалгаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хүнсний тухай хууль, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, баяжуулсан хүнсний тухай хууль, органик хүнсний сургалтыг МХГ, ХХААХҮЯамтай хамтран 1 удаагийн сургалтыг 80 иргэнд цахимаар зохион байгуулсан.	Хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.		Хэнтий аймгийн мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтын удирдамж төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д заасан үндэслэлээр хяналт шалгалт хийж Монгол улсын Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Мах махан бүтээгдэхүүн эрүүл ахуй аюулгүй байдлын үндсэн шаардлага MNS5023:2001, Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодлын шошгололтод тавих шаардлага MNS6648:2016 стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн дутагдлыг арилгуулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч шалгалт хийж ажиллалаа.	100%

19		2.4.2. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг сайжруулна.	2021 - 2025	-	Ажлын гүйцэтгэлээр	Барилга угсралтын ажлын зургийн даалгаварт ногоон байгууламжийн төлөвлөлтийг тусгаж байна. Зураг, төсөлд тусгагдсан ногоон байгууламжийг байгуулж байгаа бөгөөд хэнтий аймгийн хэмжээнд 1 хүнд 4м2 талбай бүхий ногоон байгууламж ноогдож байна.	Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.		2022 онд Хэнтий аймгийн хэмжээнд шинээр 56 барилга байгууламж барих хүсэлт ирүүлсэн бөгөөд тэдгээрийн нийт 9380945 м2 эдэлбэр газрын 30 хүртэл хувь буюу 2814283 м2 газарт тохижилт ногоон байгууламж байгуулахаар зургийн даалгаварт тусгаж холбогдох газруудад хүргүүлсэн. Энэ онд шинээр хийгдсэн ногоон байгууламж тохижилтын хэсэг тусгагдсан 18 барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулаад байна.	100%
20	2.4. Хүнд ээлтэй амьдрах орчин	2.4.3. Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	хэрэгжилтээр	Чингис хотын агаарын чанарын 1-р бүс 328 га, 2-р бүс 2932 га-аар тус тус тогтоож зураглан, бүсэд мөрдөх журам боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа зохион байгуулж, батлуулахаар БОАЖЯ-д уламжилсан. Чингис хотын хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан Хэрлэн сумын ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. 2021 онд бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулж нийт 55.0 мян мод тарьж төв суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг 6 га -аар нэмэгдүүлж нийт 51 га-д хүргэсэн. "Өрх бүр ногоон төгөл" аяныг хэрэгжүүлж нийт 2000 гаруй өрх тус бүр 3-40 ш мод буюу нийт 7200 гаруй мод тарьж оролцлоо.	Чингис хотын агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам батлуулж, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна. Ногоон байгууламжийн талбайн хэмжээг 5 га-аар нэмэгдүүлнэ.		Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Аймгийн Засаг даргын 2022 оны А/492/А/557 дугаар хамтарсан шийдвэрээр Чингис хотын агаарын чанарын 1, 2 дугаар бүсийг тогтоож, бүсэд мөрдөх журмыг баталсан. Батлагдсан журмыг ХЗЯаманд улсын нэгдсэн сангийн бүртгэлд бүртгүүлж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2022 оны агаарын бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тооллогоор аймгийн хэмжээнд нийт 7024 айл өрх тоологдсоноос ердийн галлагаатай айл өрх 6007 /89%/, сайжруулсан зуухтай айл өрх 1017 /11%/ байна. өмнөх оноос агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо 23%-иар буурсан байна. Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө /2023-2032/ -г боловсруулан аймгийн ИТХ-ын 2022 оны Арвантавдугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа. Аймгийн төвийн ил задгай хог хаягдлыг 2 удаагийн бүх нийтийн их цэвэрлэгээгээр цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгийг хашаажуулах ажлыг зохион байгуулснаар, 3600 га газрын хөрсний бохирдлыг буурууллаа. Аймгийн хэмжээнд төв суурин газарт нийт 148.7 мянган мод таригдаж, ногоон байгууламжийн хэмжээ 29.5 га талбайгаар нэмэгдсэн.	100%

21		2.4.4. Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Ажлын гүйцэтгэлээр	"Хэрлэн сумын үерийн далангийн ажил 40%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Цэнхэрмандал сумын үерийн далангийн ажил ашиглалтад орсон. Хэрлэн сумын автозамын 8,6 км ус зайлуулах сувгийн ажил дууссан."	Хэрлэн сумын үерийн далангийн ажил үргэлжлүүлнэ.		Хэрлэн сумыг үерийн уснаас хамгаалах ажлын хүрээнд нийт 9669м урт үерийн далан хотын төв зам дээр ус зайлуулах сувагчлал хийгдэхээс 2021 онд 1009 метр урт даланг хийж гүйцэтгэж ашиглалтад оруулсан бол 2022 онд нийт 8660 метр урттай үерийн хамгаалалтын далангийн ажил 40%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа ба нийт ажлын явц 60%-ийн гүйцэтгэлтэй байна. Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах системийн зураг төслийн ажил хийгдэж дууссан. Магадлалын шатанд байна.	90%	
22	2.5. Хөдөлмөрийн зах зээл	2.5.1. Хөдөлмөр эрхлэлийн түвшинг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Хувиар	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 3 арга хэмжээ, 6 төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр Хөдөлмөр эрхлэлтийн төвшин өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өссөн.	63.7		Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 223 иргэнд 1.366.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Мөн 502 ажил олгогчийн 1270 ажлын байрны захиалгад 1250 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучилсан ба ковид 19 цар тахлын дараа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сэргэж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нэмэгдэж, үүнийг дагаад хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өсч 74.3% болсон.	100%	
23		2.5.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	2021 - 2025	-	албан бус хөдөлмөр эрхлэгчдын тоо	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг тогтмолжуулан сайжруулснаар тоон мэдээлэл бодитой гардаг болсон. 2020 онд аймгийн хэмжээнд бүртгэлтэй 23096 албан бус хөдөлмөр эрхлэгчид байна. 2021 оны албан бус хөдөлмөр эрхлэлтийн статистик мэдээлэл гараагүй байна.	Албан бус хөдөлмөр эрхлэлгчдийн бүртгэлийг шинэчлэн ХЗЗ-н бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.		Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа 151 иргэнийг мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн оруулсан.	100%	
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА											

24	3.1. Нийгмийн хамгаалал	3.1.1. Халамжийн үйлчилгээг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	2021 - 2025	-	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо	2021 оны жилийн эцсийн байдлаар 774 өрхийн 4011 иргэнд 1,1 тэрбум төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэн ажиллаа.	3800		2022 онд аймгийн хэмжээнд хүнсний эрхийн бичиг авдаг 62 өрхийн 456 иргэн хасагдаж, 645 өрхийн 1766 хүүхэд, 1563 том хүн, нийт 3329 хүн одоогоор тус үйлчилгээг авч байна. 2022 онд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 656 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан, бүлгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулж, 279 иргэнийг байнгын болон түр ажлын байранд зуучлан ажилласан. Жилийн эцсийн байдлаар нийт 707 өрхийн 3593 иргэнд 503.632.000 төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэгийг 35 дэлгүүрээр дамжуулан олгон ажиллаа.	100%
25		3.2.1. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулж дэмжинэ.	2021 - 2025	-	Зээлд хамрагдсан иргэдийн тоо	Нийт 90 иргэнд зээл олгосон.	70		2022 оны 05 дугаар сарын 1-ний байдлаар нийт 28 иргэнд зээл олгосон.	40%
26	3.2. Орлогод нийцсэн орон байр	3.2.2. Дотооддоо үйлдвэрлэсэн барилгын зарим үндсэн нэр төрлийн хямд материалаар барьсан бага өртөгтэй орон сууцаар хангана.	2021 - 2025	-	ОНӨҮГ байгуулсан эсэх	"Хэнтий орон сууц" ОНӨААТҮГ-ыг аймгийн ИТХТ-ийн 2021 оны 23-р тогтоолоор байгуулж, захиалгаар 30 айлын 3 блок орон сууцны барилгын ажлыг эхлүүлээд байна	хямд үнэтэй орон сууц ашиглалтад оруулна.		Аймгийн төсвийн хөрөнгөөр 60 айлын орон сууцны 1 барилга, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууцны 1 барилга тус тус ашиглалтад орсон.	100%
27		3.3.1. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025	-	Төсөл хөтөлбөрийн хүрээнд байнгын ажлын байртай болсон залуучуудын тоо	2021 онд ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөлд 83 ажилгүй залуучуудыг хамруулж, Хэнтий аймагт 26 нь байнгын ажлын байраар хангагдсан. Мөн гарааны бизнес эрхлэгч 1 залуу гэр бүлд 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	30-аас доошгүй залуучуудыг байнгын ажлын байраар хангана.		Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 58 дугаар тогтоолоор батлагдсан Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх "Оролцоо" төсөлд хамрагдахаар 27 ажил хайгч залуу бүртгүүлснээс 15 нь сургалтад хамрагдаж, 5 нь байнгын ажлын байранд зуучлагдаж, 10 нь түр ажлын байраар хангагдсан. Мөн Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн Шилдэг "Старт ап" баг шалгаруулах арга хэмжээнд шалгарсан 2 багийн 5 залууд эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй нийт 20 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож 5 ажлын байр бий болсон.	60%
28		3.3.2. Малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.	2021 - 2025	-	Гэрээт малчнаар ажиллаж байгаа иргэний тоо	Гэрээт малчин арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж, туслах малчнаар ажиллаж байгаа иргэдийн судалгаа мэдээллийг гаргаж 2021 онд 93 туслах малчинтай гэрээ байгуулан ажиллаж байна.	100 туслах малчин		Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/55 дугаар тушаалаар батлагдсан "Туслах малчинтай байгуулах хөдөлмөрийн гэрээ"-ний загвараар 17 сумын нийт 131 ажил олгогч 142 туслах малчин өрхтэй гэрээ хийж, 160 байнгын ажлын байр бий болгон ажиллаа.	100%

29	3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	3.3.3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	аялал жуулчлалын салбарын орлого нэмэгдсэн эсэх	2021 онд 5 аж ахуйн нэгж үйл ажиллагаа шинээр эрхлэх болон өргөжүүлэлт хийж 60 орчим ажлын байрыг бий болгосноор аялал жуулчлалын салбарын ажлын байр 7.4 хувиар нэмэгдэж, дотоодын жуулчид нэмэгдэж, 8.0 тэрбум төгрөгний орлого бий болгож өмнөх оноос 10 хувиар нэмэгдүүлсэн.	Иргэд, аж ахуйн нэгжийн аялал жуулчлалын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж аймгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.		2022 онд аялал жуулчлал, үйлчилгээний салбарт нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид болон шинээр үйлчилгээ эрхлэгч ААН 1, иргэдийн хоршоо 1, бүлэг нөхөрлөл 2, өрх 16, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн 4 аж ахуйн нэгж нэмэгдэж нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэдийн тоо өмнөх оноос 12%, аж ахуйн нэгж 9.7%-аар тус тус нэмэгдсэн. Мөн энэ онд гадаад жуулчдын тоо 719, дотоод жуулчдын тоо 54 мянга хүрч, эдийн засгийн орлого 8,2 тэрбум болж, ажлын байр 10,2 хувиар нэмэгдлээ.	100%
30		3.3.4. Хоршоологчдыг дэмжих арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	үйл ажиллагааны гүйцэтгэлээр	Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог хангах нь Импакт төсөлтэй хамтран 01 дүгээр сард Мөрөн, Биндэр суманд түүхий эд бэлтгэн нийлүүлэх чиглэлээр "Мандах мөрөн" "Өгөөж баян биндэрьяа" 2 хоршоо байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Загвар хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор импакт төслөөс 700 мянган төгрөгний үнэ бүхий түүхий эдийг жинлэх жин болон 25,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Мөн тус төслөөс 38 сая төгрөгийн өртгөөр түүхий эдийн стандартын шаардлага хангасан агуулах барьж хүлээлгэн өгч ашиглалтанд оруулахад бэлэн болоод байна. мөн "Хоршооны сайн засаглалыг хөгжүүлэх нь", "Санхүү бүртгэл" сэдэвт 2 удаагийн сургалт цахимаар зохион байгуулсан.	Аймаг бүр "Нэг Загвар хоршоо"-г байгуулж, дэмжлэг үзүүлсэн байна.		Баян-Овоо суманд Баялаг гүрэм загвар хоршоог байгуулан 38 сая төгрөгийн өртөгтэй хонь хяргах төхөөрөмжийг дэмжлэг болгон үзүүлж ажилласан.	100%

31	3.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	3.4.1. Хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Биеийн тамираар хичээллэгч-дийн тоо	Аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын чиглэлээр 23 спортын холбоо, 6 төрийн бус байгууллага, 6 клуб үйл ажиллагааг явуулж байна. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох, иргэдийг спортоор хичээллүүлэх, уралдаан тэмцээнд хамруулах, нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээнүүд болон улсын хэмжээний 3 арга хэмжээ "Цахим гүйлт 2021", "Дасгал хөдөлгөөн хийцгээе" сарын аян, "Цахим гимнастра"-г зохион байгуулж, биеийн тамир, спортын арга хэмжээнд нийт 11000 иргэд хамрагдсан. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3800-аар нэмэгдсэн байна.	Биеийн тамир, спортын арга хэмжээнд нийт 10000 иргэдийг хамруулсан байх		2022 онд аймгийн хэмжээнд "Илүүдэл жингүй- эртэч Монгол аяныг амжилттай 3 сарын турш зохион байгуулан 5500 иргэдийг Өглөөний дасгалд хамруулсан. Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр 32 холбоо, 2 ТББайгууллага үйл ажиллагаа явуулж байна. 2022 онд биеийн тамираар хичээллэгчдийн тоо 10100 иргэдбайгаа нь 2021 оны мөн үеээс 1600 -н хүнээр нэмэгдсэн байна.	100%	
32		3.4.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт цогцолбор, талбайг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Шинээр ашиглалтад орсон спортын зориулалтын стандарт цогцолбор, талбайн тоогоор	2021 онд Дэлгэрхаан сум, Өлзийт тосгонд ЕБ-ын сургуулийн шинэ спорт заал ашиглалтанд орж, Дадал сумын спорт цогцолбор 90%-ийн гүйцэтгэлтэй байна.	Дадал сумын спорт заал ашиглалтанд оруулна.		2022 онд Дадал суманд 1.8 тэрбум төгрөгний санхүүжилтээр 350 хүний суудалтай Спортын заал ашиглалтанд орсон. Хэрлэн 1, Хэрлэн 4 сургуулийн спорт заал 2023 онд ашиглалтанд орно.	100%	
33		3.4.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	2021 - 2025	-	Биеийн тамираар хичээллэгчдийн тоо	Биеийн тамирын арга хэмжээнд нийт 8200 иргэн хамрагдсан нь 2020 оны мөн үетэй харьцуулахад 4400-аар нэмэгдсэн байна.	8200		Нийтийн биеийн тамирын арга хэмжээнд нийт 10100 иргэн хамрагдсан нь 2021 оны мөн үетэй харьцуулахад 1600-аар нэмэгдсэн байна.	100%	
<b>4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ</b>											
34		4.1.1. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн бодлого баримтална.	2021 - 2025	-	Бодлогыг баримтлан төсөв батлуулсан эсэх.	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар 2021 оны төсвийг 96670.3 сая төгрөгөөр батлуулан, төсвийн тухай хууль болон холбогдон гарсан тогтоол шийдвэр, журмын хэрэгжилтийг ханган, батлагдсан төсөвт багтаан ажилласан.	-		Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралдаанаар 2022 оны төсвийг 63.7 тэрбум төгрөгөөр батлуулан, төсвийн тухай хууль болон холбогдон гарсан тогтоол шийдвэр, журмын хэрэгжилтийг ханган, батлагдсан төсөвт багтаан ажилласан.	100%	
35		4.1.2. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр тогтвортой өсгөж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Дотоодын нийт бүтээгдэхүүний дүнгээр	2020 оны ДНБ 481,007.2 сая төгрөг буюу 2019 оноос 5420.8 сая төгрөгөөр өссөн байна. 2021 оны ДНБ-ний дүн гарах хугацаа болоогүй байна.	Дотоодын нийт бүтээгдэхүүн өссөн байна.		2021 оны ДНБ 599,760.1 сая төгрөг буюу 2020 оноос 118,752.9 сая төгрөгөөр өссөн байна. 2022 оны ДНБ-ний дүн гарах хугацаа болоогүй байна.	100%	



36	4.1. Чадварлаг Хэнтийчүүд	4.1.3. Төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн бизнес эрхлэгчдийг чадавхжуулна.	2021 - 2025	-	Төсөл, хөтөлбөр гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн эсэх	2021 онд АХБ-ны 8,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай 3000м3/хоног цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулсан. АХДКС-ийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан нисэх буудлын хөөрч буух зурвасын барилгын ажил үргэлжилж, Дэлхийн банкны 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр, Хэрлэн сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх ажлын гэрээ байгуулагдаж Бор-Өндөр сумын ажил эхэлсэн. Япон улсын ЭСЯ-ны Өвсний үндэс төслийн 500 сая төгрөгийн хөрөнгөөр Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн засвар хийгдэж ашиглалтад орлоо. АНУ-ын армийн корпорацийн хөрөнгө оруулалтаар Дадал суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил эхэлсэн.	Төсөл, хөтөлбөр гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдүүлнэ		АХДКС-ийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан нисэх буудлын хөөрч буух зурвасын барилгын ажил хийгдсэн. Дэлхийн банкны 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр, Хэрлэн сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх ажлын гэрээ байгуулагдаж ашиглалтад оруулахад бэлэн болсон байна. АНУ-ын армийн корпорацийн хөрөнгө оруулалтаар Дадал суманд 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажил 2022 оны 10 дугаар сарын 3-ны өдөр ашиглалтад рүлээн авсан.	100%
37		4.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Нийт худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлээс авсан бараа, бүтээгдэхүүний хувь	22 төсвийн ерөнхийлөн захирагчийн хамтран ажиллах гэрээнд дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах талаар тусгуулж, хэрэгжилтийг тооцож байна. 18 сум, 4 тосгоны тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага болох эмнэлэг, цэцэрлэг, сургуулийн хувьд хүнсний бараа бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлээс худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүрэн байршуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Энэ хүрээнд 2021 оны 4 дугаар улирлын байдлаар 32 нэр төрлийн 243.7 сая төгрөгийн дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн худалдан авсан байна.	-		Сумдын Засаг дарга нарын 2022 оны гэрээнд холбогдох заалтуудыг тусгаж ажилсан. Мөн засгийн газрын 90 тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан 3,666,650,953 төгрөгийн дүн бүхий бараа, бүтээгдэхүүнийг аймгийн хэмжээнд худалдан авсан байна.	100%

38	4.2.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг өсгөж, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж, экспортыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	үйлдвэр баригдсан эсэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн суманд ноос угаах үйлдвэр шинээр ашиглалтанд орж Сүхбаатар, Хэнтий аймгийн малчдаас 800 тн ноос худалдан авч, анхан шатны боловсруулалт хийж угаан 70-80 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан.	малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг барьсан байна.		Баян-Овоо суманд Баялаг гүрэм загвар хоршоог байгуулан үйл ажиллагаа нь жигдрэн ажиллаж байна. Биндэр, Мөрөн сумдад "Өгөөж баян биндэръяа", "Мөнх мандах мөрөн" зэрэг жишиг хоршоодыг байгуулж түүхий эдэд нэмүү өртөг шингээн гадаадын зах зээлд борлуулаад байна.	90%
39	4.2.2. Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох замаар олон улсын аялал жуулчлалын зах зээлээс жуулчид татаж, зорин ирэх жуулчдын тоог өсгөнө.	2021 - 2025	-	жуулчдын тоо өссөн эсэх	Аялал жуулчлалын технологийн дэвшил, цахим орчны гадаад дотоод сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор гар утасны хөтөч аппликейшнийг Англи, Монгол хэл дээр ашиглалтад оруулж хэрэглэгч, ашиглагчийн тоог нэмэгдүүллээ. Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх чиглэлийг хүргүүлж, дэмжиж ажилласнаар 2 суманд 2 жуулчны баазыг түшиглэн 3 шинэ аяллын бүтээгдэхүүн бий болголоо. 2021 онд дотоодын жуулчдын тоо 53,7 мянгад хүрч өмнөх оноос 10 хувиар өссөн. Цар тахлын улмаас гадаад жуулчид өсөөгүй.	Дотоодын жуулчдын тоо өссөн байна.		Хэнтий аймгийн төвд Аялал жуулчлалын мэдээллийн төвийг нээж, үйл ажиллагааг жигдрүүлэн иргэд, жуулчдад мэдээлэл өгч ажиллаж байна. Энэ хугацаанд гадаадын 6, дотоодын 35 иргэн үйлчлүүлд байна. Мөн цахимаар 80 орчим иргэнд түүхэн дурсгалт газар болон аяллын маршрутын мэдээллийг хүргэж үйлчиллээ. Хэнтий аймгийн хэмжээнд албан ёсны бүртгэлтэй 6 эвент арга хэмжээний 2 нь хоёр жилд нэг удаа зохион байгуулагддаг ба энэ онд зохион байгуулсан "Тогорууны баяр", "Талын гөрөөчин-тайга нохой", "Галшар адууны баяр", "Талын түмэн адуу" 4 эвент арга хэмжээнүүдэд гадаадын 109, дотоодын 2410-н жуулчин, тур оператор 20 гаруй ХХК оролцож үзэж сонирхсон байна. 2020 онд дотоодын жуулчид 48.6 мянга, гадаадын жуулчид 0, 2021 онд дотоодын жуулчид 53.7 мянга, гадаадын жуулчид 0 байсан бол 2022 онд дотоодын жуулчид 54.8 мянга гадаадын жуулчид 719 болж нэмэгдсэн. Дотоод жуулчдын тоо 12.7 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.	100%

40		4.2.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Гүйцэтгэлээр	Дэлхийн банкны 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр, Хэрлэн сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх ажлын гэрээ байгуулагдаж Бор-Өндөр сумын ажил эхэлсэн.	Инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлсэн байна.		"Эрчим хүчний яаны захиалгаар Дэлхийн банкны эрчим хүчний төсөл-2 БЗӨБЦТС ТӨХК-ийн Хэнтий ЦТСС-ын 6кВ-ын РП-1 хаалттай хуваарилах байгууламжийн шинэчлэлийн ажлыг 2022 оны 04 сарын 15-наас эхлүүлсэн ба одоогийн байдлаар 95 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгээд 2023 оны 02 дугаар сард багтаан байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Мөн Дархан, Баян-Овоо, Бор-Өндөр, Хэрлэн сумдын шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчийг эрчим хүчинд холбох ажил хийгдэж эхэлсэн бөгөөд 2022 оны байдлаар Баян-Овоо, Дархан, Бор-Өндөр сумын ажил бүрэн дууссан. Хэрлэн сумын шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчийг эрчим хүчинд холбох ажил удаашралтай байна.	90%
41	4.2. Эдийн засгийн чиглэл	4.2.4. Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох авто зам, ус, эрчим хүчний төслүүдийг Бор-Өндөр, Дархан сум, Бэрх тосгоныг түшиглэж хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	хэрэгжсэн эсэх	Бор-өндөр, Баян-Овоо сумдад хайлуур жонш баяжуулах үйлдвэр, Бор-Өндөр суманд төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төслүүдийг мэргэжлийн байгууллагуудаар судлуулж, газар, техникийн нөхцөл олгох, байгаль очинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийх зэрэг үйл явцыг дэмжиж, төр хувийн хэвшилтэй хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн.	төсөл боловсруулсан байна.		Бор-өндөр, Дархан сумдад хайлуур жонш баяжуулах, олборлох үйлдвэр, Бор-Өндөр суманд төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийн төслүүдийн хэрэгжилттэй танилцаж, уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төр хувийн хэвшил хамтран ажиллах талаар хэлэлцлээ. Мөн "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсаны дагуу аж үйлдвэрийг хөгжүүлэх, төв суурын газрын төвлөрлийг сааруулах хүрээнд "Аж үйлдвэрийн нэгдсэн парк бүхий шинэ Бор-Өндөр хот байгуулах" төслийг Засгийн газрын түвшинд хэлэлцүүлж, холбогдох хууль эрхзүйн зохицуулалтыг бий болгох, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх санал хүсэлтийг хүргүүлээд байна.	80%

42	4.2.5. Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, цахилгаан эрчим хүчний хангалтыг өсгөнө.	2021 - 2025	-	-	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн сумын II, III, V багуудын нутаг дэвсгэрт 0.4 кВт цахилгаан эрчим хүчээр хангах төслийг хэрэгжүүлж, 3 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамын угсралтын ажлыг "Эрчим Өгий" ХХК гүйцэтгэж 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байнгын ашиглалтад оруулсан. Тус төсөл хэрэгжсэнээр 120 нэгж талбар дахь 192 айл өрх цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон.	Шинэ суурьшлын бүсийг үе шаттай ЦЭХ-ээр хангана.		ОНХС-ийн 89.6 сая төгрөгийн санхүүжилтээр Жаргалтхаан сумын 2 км ЦДАШ байгуулсан бол, 181.6 сая төгрөгийн санхүүжилтаар Батноров сумын шинэ суурьшлын бүсэд 0.4-ийн агаарын шугам байгуулаах ажилд төндөр зарлаж "АНАРЗОНЕ" ХХК шалгарч, тухайн оны хуваарьт ажлаа гүйцэтгэсэн. Үүнээс гадна Өмнөдэлгэр суманд 50 кВа, 30 кВа-гийн 2 дэд станцын ажлыг ашиглалтад хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн 650 сая төгрөгийн санхүүжилтээр Баянхутаг, Батширээт, Дадал, Норовлин, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдад шинэ суурьшлийн бүсэд цахилгаан хангамж татах ажил хэрэгжиж байна. Баян-Овоо сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн ажил бүрэн дууссан.	100%
43	4.2.6. Зүүн бүсийн логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.	2021 - 2025	-	Хэрэгжитээр	Логистикийн төв байгууллах зургын ажлыг эхлүүлсэн байна.	-		Монгол шуудан ХХК-тай хамтарч зүүн бүсийн тээвэр, логистикийн байгууламж барих эскиз зурагт санал солилцож аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулж Аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлэн батлуулахаар хэлэлцэж байна.	30%
44	4.2.7. Улаанбаатар-аймаг-сум хоорондын нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Гүйцэтгэлээр	""Өндөрхаан нисэх буудал""-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг ЗТХЯ-аас зарласан. Тус цогцолборын хөөрч буух зурвас байгуулах ажлын гүйцэтгэл 70%-тай үргэлжилж байна. ""Дэлүүн Болдог нисэх буудал""-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25%-тай үргэлжилж байна."	Өндөрхаан нисэх буудлын барилгын ажил үргэлжилнэ. Дэлүүн Болдог нисэх буудлын барилга ашиглалтад орно.		Өндөрхаан нисэх буудал"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25%, "Дэлүүн Болдог нисэх буудал"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40%-тай үргэлжилж байна.	30%
45	4.2.8. Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн сумд руу авто зам барина.	2021 - 2025	-	Гүйцэтгэлээр	Чингис хотоос 70 км /Бэрх тосгон хүртэл/ суурь асфальтан хучилтаа бүрэн хийсэн, ирэх онд үлдсэн замын өнгө давхаргын асфальт хучилт, хэвтээ тэмдэглэгээг хийхэд бэлэн болгоод байна.	Чингис хот-Бэрх 50 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орно.		Чингис хотоос Бэрх тосгон хүртэл 70 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон. 2023 онд Бэрх тосгон Батноров сум хүртэл 35 км автозам ашиглалтад орно.	100%

46		4.3.1. Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагыг сайжруулж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	2021 - 2025	-	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжсэн эсэх.	Хэнтий аймгийн хэмжээнд бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ХЗХоршооны үндсэн-1, салбар-4 мөн ББСБайгуулага үндсэн-2, салбар-2 нийт 9 байгууллага санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс 2021 онд "Гялс кредит" ББСБайгууллагын салбар шинээр нэмэгдэн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд иргэдэд зориулж 10 сая хүртэлх төгрөгийн цахим зээл олгох үйлчилгээг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна. Дээрх байгууллагуудын тайланг авч, зөвлөмж чиглэл хүргүүлэн уялдаа холбоог сайжруулж үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжсэн байна.		Хэнтий аймгийн хэмжээнд бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхлэн явуулдаг ХЗХоршооны үндсэн-1, салбар-4 мөн ББСБайгуулага үндсэн-2, салбар-8 нийт 15 байгууллага санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу иргэдэд санхүүгийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс 2022 онд "Сэндли" ББСБ, "Таван богд финанс" зэрэг ББСБайгууллагын 5 салбар шинээр нэмэгдэн үйл ажиллагаа явуулж байна. "Сэндли" ББСБ-ын салбарууд нь нь иргэдэд зориулж 30.0 сая хүртэлх төгрөгийн цахим зээл олгох үйлчилгээг мөн цахим төлбөр тооцоо болон Япон, Америк, Австрали, Европын холбооны 27 улсад хамгийн бага шимтгэлтэйгээр мөнгөн гуйвуулгын үйлчилгээг шинээр нэвтрүүлэн ажиллаж байна.	100%
----	--	--	-------------	---	--	---	---	--	--	------

47		4.3.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Хэрэгжүүлсэн эсэх	Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Эрүүгийн цагдаагийн албаны дарга, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын дарга нарын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр баталсан "Мөнгө угаалт-Хяналт-Эрчимжүүлэлт" нэгдсэн арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газраас 3 бүлэг 9 заалт бүхий салбар төлөвлөгөөг боловсруулан арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэртээ зохион явуулж үр дүнг тооцсон. Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх газар, гадаадын хөрөнгө оруулалттай шашны байгууллага, салбар төлөөлөгчийн газрууд зэрэг хөрөнгө мөнгө ихээр төвлөрдөг газруудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр харилцан мэдээлэл солилцож ажилласан.	-	"Терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 3 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлээд байна. 2022 оны 3, 10 дугаар сард Терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, хүний нууцын хадгалалт хамгаалалтын талаар 7 сумын 220 төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулж ажиллаа. Банкны салбаруудын ажилтнууд болон албан байгууллагуудаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар сургалтыг зохион байгуулж арилжааны банкууд хяналт тавин ажиллаж байна. Цахим гэмт хэрэг, залилангаас урьдчилан сэргийлэх зорилгоор Төв Монголбанк, ЦХХХЯам, ЦЕГ-тай хамтарсан Бүү шилжүүл аяныг зохион байгуулж иргэдэд сурталчилж, сургалтуудыг хийсэн байна.	100%
48		4.3.3. Банкны салбаруудын орон нутгийн байгууллагуудын уялдааг хангаж, иргэдэд найдвартай, шуурхай, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулна.	2021 - 2025	-	Банкны салбаруудын үйлчилгээ үзүүлэх нөхцөл сайжирсан эсэх.	Хэнтий аймгийн банкууд салбар нэгжээрээ дамжуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г харилцагч иргэд олон нийтэд сурталчлан хэрэгжүүлсэн. Тус хөнгөлттэй зээлийг 87 ААНэгжид 12.2 тэрбум төгрөгийн, 319 иргэнд 11 тэрбум төгрөгийн зээлийг олгож, 418 ажлын байр хадгалагдсан байна. Мөн ХАА-н хөнгөлттэй зээлийг 5 ААНэгжид 363.9 сая төгрөгийн, 476 иргэнд 6.6 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна. Ипотекийн зээлийг 10 иргэнд 599.4 сая төгрөгийн ипотекийн зээлийг олгож ажилласан.	-	Хэнтий аймгийн хэмжээнд 2022 онд банкны салбар орон нутгийн байгууллага, иргэдийн уялдаа холбоог хангаж ажиллах зорилгоор олон нийт иргэдэд санхүүгийн мэдлэгийг нь дээшлүүлэх, хуримтлалын ач холбогдлыг ойлгуулах талаар Дэлхийн мөнгөний 7 хоног, Дэлхийн хуримтлалын өдөр аянуудыг зохион байгуулж ажилласан.	100%

49	4.4. Бүс нутгийн хамтын ажиллагаа	4.4.1. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон гуравдагч орнуудтай худалдаа, нийгэм, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, экспортыг дэмжих, арга хэмжээ авна.	2021 - 2025	-	хамтран ажилласан байдал	2021 онд ОХУ болон БНХАУ-аас аймгийн хэмжээнд 36.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татаж эдийн засгийн харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.	-		2022 онд ОХУ болон БНХАУ-аас аймгийн хэмжээнд 101.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татаж эдийн засгийн харилцааг өргөжүүлэн ажиллаж байна.	100%
50	4.5. Хэнтийн брэнд бүтээгдэхүүн	4.5.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинэ санаа, оюуны бүтээл, дэвшилтэт техник, технологид тулгуурлан Хэнтийд үйлдвэрлэсэн эрүүл чанартай бүтээгдэхүүний Брендийг бий болгон, гадаад дотоодын зах зээл дахь борлуулалтын сувгийг тэлнэ.	2021 - 2025	-	Ажлын гүйцэтгэлээр	Намрын баяр нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж 2 шилдэг ногоочин, 5 шилдэг брэнд бүтээгдэхүүн шалгаруулж ажилласан. Хэнтийн брэнд бэлгийн багц (цөцгийн, талх, шимийн архи, хунчир г.м) гарган төрийн хүндэтгэлийн арга хэмжээнд гарын бэлэг болгон өгч хэвшээд байна.	10-аас дээш шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж ажилласан байна.		Хэнтий намрын ногоон өдрүүд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж 2 шилдэг ногоочин, 6 шилдэг брэнд бүтээгдэхүүн шалгаруулж ажилласан. "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдаанд шилдэг мод, модон эдлэлийн төрлөөр Дадал сумын Э.Золжаргал, шилдэг гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн төрлөөр Хэрлэн сумын А.Пунцаг, Шилдэг оёмол бүтээгдэхүүн төрлөөр Батноров сумын М.Мөнгөнбагана, шилдэг арьс ширэн эдлэл төрлөөр Хэрлэн сумын Ч.Батбилэг, шилдэг шинэ санаа шилдэг бүтээл /Олны таашаалд нийцсэн бүтээгдэхүүн/ төрлөөр Батноров сумын А.Цогтбаатар нар тус тус шалгарлаа	90%

5. ТАВ. ЗАСАГЛАЛ

51	5.1. Цахим Монгол	5.1.1. "E Mongolia" болон "erp.e-mongolia" системийг аймгийн хэмжээнд үе шат дараатайгаар нэвтрүүлж төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэж, ил тод байдлыг хангана.	2021 - 2025	-	Биечлэн үйлчилгээ авсан иргэдийн хувь	"E Mongolia" болон "Erp.e-mongolia" системд Хэнтий аймгийн төрийн 71 байгууллагын үйл ажиллагааг цахимжуулж, тус системийн ач холбогдлыг иргэд олон нийтэд сурталчлан таниулсны үр дүнд биечлэн үйлчилгээ авсан иргэдийн тоо өмнөх жилээс 19.8 хувиар буурсан байна. www.erp.e-mongolia.mn системд төрийн 187 байгууллагын компьютер хэргэлдэг 1129 албан хаагчийг холбож, нийт 4798 албан хаагчийн хүний нөөцийн мэдээллийг тус системд оруулаад байна. www.erp.e-mongolia.mn системийн хэрэглээнд ажлын хэсэг 2 удаа биечлэн 4 удаа цахимаар хяналт тавихад 1129 албан хаагчаас 1050 албан хаагч буюу 93 хувь нь тус системийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж хэвшсэн байна.	Биечлэн үйлчилгээ авсан иргэдийн тоо 20 хувиар буурсан байна.		e-mongolia, erp.e-mongolia.mn системүүдийг аймгийн хэмжээнд өдөр тутмын ажил үйлчилгээндээ тогтмол хэрэглэж нийт 4868-н төрийн албан хаагчийн мэдээлэл үүсгэгдэж үүнээс идэвхтэй хэрэглээтэй 1100 байна. E-Mongolia системээр операторуудаар дамжуулан өмнөх онд 4056 үйлчилгээ үзүүлсэн бол энэ онд 3191 үйлчилгээ үзүүлж өмнөх оныхоос 20 хувиар буурсан байна.	100%
----	-------------------	--	-------------	---	---------------------------------------	--	---	--	---	------

52	5.2. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	5.2.1. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээ" арга хэмжээг хэрэгжүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар, ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулна.	2021 - 2025	-	төрийн албан хаагчтай холбоотой ирсэн өргөдөл гомдлын тоо	Төрийн үйлчилгээг шууд хүргэдэг байгууллагуудын албан хаагч нарын үйл ажиллагааг иргэд үнэлэх төхөөрөмжийг аймгийн төвийн 8 байгууллага, 13 сум 2 тосгоны нийт 239 албан хаагчид суурилуулсан бөгөөд одоогийн байдлаар дээрхи байгууллагуудаас 16.838 иргэн үйлчилгээ авсан бөгөөд түүний 16.479 иргэн буюу 97.8 хувь нь маш сайн, үнэлгээ өгсөн байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 178 төрийн байгууллагуудыг үйлчилгээний стандарттай болгосноор төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний чанар стандарт, ажлын бүтээмж сайжирч, үйлчилгээ авч байгаа иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн. Үүний үр дүнд 2021 онд төрийн албан хаагчтай холбоотой 7 өргөдөл, гомдол ирсэн.			Төрийн албан хаагчдыг чадавжуулах 2022 оны цахим сургалтын төлөвлөгөөг батлуулж, 11 удаагийн цахим сургалтыг зохион байгуулан 6300 гаруй албан хаагчид хамрагдсан. Түвшин тогтоох шалгалтын 720 албан хаагчаас авч үнэлгээ 62.4 хувь. Төрийн үйлчилгээг шууд хүргэдэг байгууллагуудын албан хаагч нарын үйл ажиллагааг иргэд үнэлэх төхөөрөмжийг аймгийн төвийн 9 байгууллага, 17 сум 2 тосгоны нийт 239 албан хаагчид суурилуулсан бөгөөд 2022 онд дээрхи байгууллагуудаас үйлчилгээ авсан 50960 иргэнээс 80.9 хувь нь буюу 41228 нь маш сайн үнэлгээ өгсөн байна. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 178 төрийн байгууллагуудыг үйлчилгээний стандарттай болгосноор төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйлчилгээний чанар стандарт, ажлын бүтээмж сайжирч, үйлчилгээ авч байгаа иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн. Үүний үр дүнд 2022 онд төрийн албан хаагчтай холбоотой 2 өргөдөл, гомдол ирсэн.	100%
6. ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ										
53	6.1. Эх байгаль, экосистем	6.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсцаг бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах ажлыг эрчимжүүлнэ.	2021 - 2025	-	нийт нутаг дэвсгэрт ТХГН-ийн эзлэх хувиар	Аймгийн хэмжээнд 631.4 мянган га усны ай сав, усан сан бүхий газар, 2971.9 мянган га экосистемийн ач холбогдол бүхий газар, нийт 3603.4 мянган га газар нутгийг Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан нь нийт нутаг дэвсгэрийн 44.8 хувийг эзэлж байна.	45		Улсын тусгай хамгаалалттай 9 газрын 1071460 га, орон нутгийн хамгаалалттай 452 газрын 2513846,4 га, нийт 461 газрын 3585306,4 га буюу аймгийн нийт нутаг дэвсгэрийн 44,6 хувийг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна. Аймгийн төвийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт хязгаарлалтын бүсийг аймгийн ИТХ-ын 2016 оны А/13 дугаар тогтоолоор тогтоосныг аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор нэмж шинээр усан хангамжийн нөөц тогтоож, 6482.32га талбайг хамгаалалтанд авч, хамгаалалтын горимыг баталсан. Хамгаалалтын бүсийн горимыг сурталчилах 7 самбарыг байршуулсан. Өмнөдэлгэр сумын Тэнүүн гол орчмын газрыг байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авах судалгааны ажил хийгдэж байна.	99%



54		6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.	2021 - 2025	-	га талбайгаар	Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдрэлд орсон 10 га талбайд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын 10 сая төгрөгийн хөрөнгөөр техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг "Ханцомуун" ХХК гүйцэтгэж, хүлээлгэж өглөө.	10 га талбайд нөхөн сэргээсэн байна.		2022 онд 48.3 га талбайд газрын хэвлийг нөхөн сэргээх ажил хийгдсэн. Орон нутгийн төсвийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 50.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдрэлд орсон 10га, Бор-Өндөр суманд хууль бус жонш олборлолтоос үсч эвдрэлд орсон 10га, Баян-Адарга суманд хууль бус жонш олборлолтоос үүсч эвдрэлд орсон 10га, нийт 30 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба Бор-Өндөр суманд аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр техникийн нөхөн сэргээлт 18.3га талбайд хийсэн.	100%
55	6.2. Байгалийн баялгийн өгөөж	6.2.2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгоно.	2021 - 2025	-	тоогоор	Амьтны эрх хамгаалах нийгэмлэг ТББ-тай БО/2021/18 гэрээг байгуулж Мөрөн сумын Өндөрхаан уулын УТХГ-т 30 толгой "Монгол тарвага" нутагшуулах ажлыг хийж гүйцэтгүүлж, ажлын хэсэг актаар хүлээн авсан.	-		2022 онд Хэнтий аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын болон Монгол тарваганы нарийвчилсан менежмент төлөвлөгөөг батлуулахаар Мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлээд байна. Мөн амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх зорилгоор биотехникийн арга хэмжээг давхардсан тоогоор 13 суманд авсан. Нийт 2 агнуурын бүс, аймгийн хэмжээний 2 менежментийн төлөвлөгөө батлуулсан. Хэнтий аймгийн хэмжээнд 2017 оны ерөнхий агнуурын менежментийн төлөвлөгөөнд 505 тоо толгой тоологдсон бол 2022 оны ерөнхий агнуур зохион байгуулалтын хээрийн судалгаагаар 784 тоо толгой болж, 35 хувиар өссөн байна. Дэлгэрхаан суманд Эмийн ургамлын "Астра рүүт" ХХК байгальд ховордоод буй хунчир 300 га-д, чихэр өвс 150 га-д, дэрэвгэр жиргэрүү 50 га-д тус тус тариалалт хийж, эмийн ургамлын плантаци бий болгож, биологийн нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Дадал суманд байгуулагдсан мод үржүүлгийн газрын 0.2 га талбайд ховор ургамл цагаан цээнийн үрийн плантаци байгуулах талбайг бэлтгэсэн.	100%

56	6.2.3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	га талбайгаар	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Дэлгэрхаан суманд 15 га-д, ойн ангиуд, ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр Өмнөдэлгэр, Батширээт, Цэнхэрмандал суманд нийт 109 га-д, аймгийн хэмжээнд нийт 124 га талбайд ойжуулалт хийгээд байна.	Ойжуулалтын ажлыг 250 га талбайд хийсэн байна.		Улсын төсвийн хөрөнгөөр Батширээт суманд 50 га-д, Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Цэнхэрмандал, Дадал, Дэлгэрхаан, Баян-Адарга, Норовлин сумдууд, Сум дундын ойн ангиуд болон ойн мэргэжлийн байгууллагууд өөрийн хөрөнгөөр 172.5 га-д, нийт 222.5 га талбайд ойжуулалт хийж, ойн сангийн талбайг 0.03 хувиар нэмэгдүүллээ.	89%
57	6.3.1. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.	2021 - 2025	-	тоогоор	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар болон бусад хөрөнгөөр Хэрлэн голын сав газарт хамаарах Аваргын гол, Түлүүгийн хөв, Хангалын нуурын онцгой хамгаалалтын бүсэд 15 ширхэг, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газар хамаарах 10 булагт 10 ширхэг, Онон Улзын сав газарт хамаарах бүсэд 41 тэмдэгжүүлэлт хийж байршуулснаар усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалт, эрүүл ахуйн бүсийн таниулж, бүсэд мөрдөх дэглэмийн хэрэгжилтийг хангаж байна.	30-аас доошгүй тэмдэгжүүлэлт хийгдсэн байна.		Баянмөнх, Баянхутаг сумдын нутаг дэвсгэрт Хэрлэн голын онцгой хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, сурталчилан таниулах 50 ширхэг самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.	100%
58	6.3.2. Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.	2021 - 2025	-	тоогоор	Цэнхэрмандал сумын нутаг Түлүүгийн хөвийн ус халих хэсгийн даланг сэргээн засварлах ажлыг Содон түлхүүр ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээж авлаа.	1 хөв цөөрөм сэргээн засварласан байна.		БОАЖЯ/20221100502 гэрээний дагуу "Престиж Инженеринг" ХХК "Аварга Тосон нуурыг сэргээх" судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна. Бүрд нуурыг сэргээх, ус дөхүүлэх ажлыг "Усны барилга" ХХК батлагдсан зураг төслийн дагуу өндөр нь 2.7м, хярын өргөн 3.5м, 139м урттай далан бүхий 13000м.куб ус хуримтлах талбай бүхий хөв хийж, 3.9км урттай ус дөхүүлэх сувгийн ажлыг хийж гүйцэтгэн Улсын комисст хүлээлгэж өгсөн.	100%

6.3. Ус үнэт баялаг

59	6.3.3. Саарал усны технологийг ахуйн хэрэглээнд нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эхлүүлнэ.	2021 - 2025	-	Хувиар	Чингис хотод 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулснаар ахуйн бохир усыг 98% хүртэл цэвэршүүлж саарал ус гаргах боломжтой болсон.	Саарал усны хэрэглээг нэвтрүүлэх судалгаа хийнэ.		Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа сумдын инженерийн байгууламж, бохир ус зайлуулах, цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлын төлөвлөлтөд саарал усны технологийг судлан нэвтрүүлэх бодлого барьж ажилласнаар бохир усыг 95-98% цэвэрлэх технологи бүхий Чингис хотын 3000 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 2021 онд, Баямөнх суманд 50 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж 2022 онд тус тус ашиглалтад орж, цэвэршүүлсэн саарал усыг мэргэжлийн хяналтын лаборатори болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын лабораторид шинжилгээнд хамруулан ногоон байгууламжийн усалгаа, арчилгаанд ашиглах боломжтой дүгнэлт аваад байна. Мөн Батноров, Галшар сумдад 50 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулан саарал усыг шинжилгээнд хамруулж байна. Цэнхэрмандал, Баян-Адарга, Норовлин суманд 95% хүртэл цэвэршүүлэх хүчин чадалтай Microfast технологийн цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын гэрээ байгуулагдан ажил эхлээд байна.	100%
----	--	-------------	---	--------	---	--	--	---	------

60		6.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.	2021 - 2025	-	үйл ажиллагаагаар	Энэ онд 18 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж нийт 364.8 сая шоо метр хур тунадас нэмэгдүүлсэн ба нэг шоо метр тунадсанд ногдох үнэлгээ 0.21 төгрөг болж байна. Аймгийн нийт нутаг дэвсгэрийн 23.4 хувьд, үүнээс бэлчээрийн бүс нутагт 89%, газар тариалангийн бүс нутагт 11%-д хур тунадас нэмэгдүүлж ажилласнаар бэлчээрийн болон таримал ургамлын ургалт, гарц харьцангуй сайн байж, бэлчээрийн биомасс нэмэгдэж, ой хээрийн түймэр гараагүй. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зориулж БОАЖЯамнаас туулах чадвар сайтай Пургон автомашины дэмжлэг, аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажиллана.		Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг 2 хөдөлгөөнт экспедици 14 удаа зохион байгуулж ажилласан. Хур тунадасыг 51,2%-иар нэмэгдүүлсэний дүнд зуншлагын байдал нийт нутгийн 87,3% нь сайн, 12,7%-д дунд зэрэг байсан. Бэлчээрийн зуны дээд ургац 2.8-19.4ц/га. 2020-2021 оны мөн үетэй харьцуулахад 1.2-9.6 ц/га-р илүү байна. Өвөл хаврын бэлчээрийн даац багтаамж 60 гаруй хувьд нөөцтэй болон хүрэлцээтэй, 40 орчим хувьд хэтэрсэн байна. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд зориулж аймгийн Засаг даргын нөөц сангийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100%
61	6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон үсгийг	6.4.2. Аймгийн хэмжээнд ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Хэрэгжилтийн хувиар	Аймгийн хэмжээнд тендер шалгаруулахад хүлээн авдаг бичиг цаасан хэлбэрийн материалыг 100% цахим хэлбэрт шилжүүлээд байна.	Ногон худалдан авалтыг дэмжинэ.		Аймгийн хэмжээнд тендер шалгаруулахад хүлээн авдаг бичиг цаасан хэлбэрийн материалыг 100% цахим хэлбэрт шилжүүлээд байна.	100%

62		6.4.3. Аймгийн болон сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж эхлүүлнэ.	2021 - 2025	-	үйл ажиллагааны хэрэгжилтээр	Бор-Өндөр сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор ОНТ-ийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Сумдын айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх, менежментийг сайжруулах зорилгоор ЦЭХ-ний төлбөртэй нэгтгэн төвлөрүүлэлт хийх гэрээний төслийг боловсруулж сумын Засаг дарга нарт хүргүүлсэн. Баян-Адарга, Биндэр, Бор-Өндөр, Хэрлэн, Дархан сумдад тохижилт үйлчилгээний газар тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ба Батширээт, Бор-Өндөр сум дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор хог хаягдал нягтруулан шахах /пресслэгч/ тоног төхөөрөмжийг худалдан авч ашиглалтад оруулсан. Энэ онд Чингис хотод 10 тн дахивар хог хаягдлыг ангилан ялгаж, эдийн засгийн эргэлтэнд оруулсан.	2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн байна.	Хэнтий аймгийн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө /2023-2032/ -г боловсруулан аймгийн ИТХ-ын 2022 оны Арвантавдугаар хуралдаанаар хэлэлцүүлж батлуулаа. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, иргэдийн оролцоо, хандлагыг нэмэгдүүлж байна. Баян-Адрага сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор "Дахивар хог хаягдал цуглуулах цэг" байгуулаад байна. Мөн Дархан сум хог хаягдал пресслэгч тоног төхөөрөмж, Дэлгэрхаан сум хог тээврийн автомашин шинээр авсан. ТАЖХТөслийн санхүүжилтээр Дадал суманд 2-р зэрэглэлийн лансфилл цэг байгуулагдаж байна. Баянмөнх сум хуучин хогийн цэгийг дарж булшлан шинээр лансфил хогийн цэг бий болгосон зэрэг 4 суманд хог хаягдлын менежментийг сайжруулаа. Энэ онд 2 аж ахуйн нэгж 10тн хуванцар, 1тн лааз, 3тн гялгар уут, 22.2тн шилийг дахин ашиглах болон дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. Энэ нь 2021 оны хог хаягдлын бүтцийн судалгаатай харьцуулахад нийт дахивар хог хаягдлын 19.3 хувийг эзэлж байна.	100%
<b>7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b>									
63		7.1.1. Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Хугацаат цэргийн албанд татагдсан иргэдийн тоогоор	ЗХЖШ-аас ирүүлсэн хяналтын тоог 100% биелүүлж ажиллаж байгаа бөгөөд өмнөх оны хяналтын тооноос 25 хувиар нэмэгдүүлж ажилласан.	ЗХЖШ-аас тогтоосон цэрэг татлагын хяналтын тоог бүрэн биелүүлж ажиллах	Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар батлагдсан хяналтын тоог 100 % биелүүлж ажилласан	100%
64		7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	-	Хэрэгжилтийн хувиар	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд томилгоожсон бүрэлдэхүүнд жил бүрийн 5, 11 дүгээр сард тодотгол явуулж, сургалтын нэгдсэн төлөвлөгөөны дагуу үүрэг гүйцэтгэх чадамжийг дээшлүүлэх зорилгоор удирдлага, бүрэлдэхүүний сургалтыг тогтмол хийж хэвшсэн.	Цэргийн дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг тогтоосон хугацаанд тодотгож ажиллах	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд томилгоожсон бүрэлдэхүүний тодотголыг тогтоосон хуваарийн дагуу тогтмол хийж, удирдах бүрэлдүүний сургалтыг 1 удаа, томилгоот бүрэлдэхүүний сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулсан	100%

65		7.1.3. Гамшгийн техник хэрэгсэл, туулах чадвартай автомашин хангалтыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлаар	Гал унтраах, аврах тусгай зориулалтын Hyundai маркийн автомашиныг Баян-Адарга сумын Засаг даргын Тамгын газарт, аймгийн ОБГ азарт туулах чадвар сайтай Ланд Крузер 78 маркийн 2 автомашиныг хүлээлгэн өгсөн.	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдал дээшилсэн байна.		Төлөвлөгөөний дагуу гал түймэр, гамшиг осолтой тэмцэхэд шаардлагатай 2 авто машиныг худалдан авч албан хэрэгцээндээ хэрэглэж байна.	100%
66	7.1. Зэвсэгт хүчин, гамшгийн эрсдэлийг бууруулах	7.1.4. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, сургуулилтыг нэмэгдүүлэх, иргэдэд гамшиг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025	-		Аймгийн Засаг даргын 2021 оны А/540 дүгээр захирамжаар Баян-Адарга сумдад Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль, А/541 дүгээр захирамжаар Гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг Цэнхэрмандал, Жаргалтхаан сумдад 3,8 сая төгрөгийг зарцуулан зохион байгуулсан. Дээрх дадлага сургуульд орон нутгийн удирдлагууд мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нийт 132 алба хаагчдыг хамруулсан. ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газар, аймгийн цаг уур, орчны шинжилгээний газрын урьдчилан мэдээлэх хэлтсээс нийт 27 сэрэмжлүүлэг мэдээг хүлээн авч "Хэнтий аймгийн ЗДТГ" фэйсбүүк цахим хуудасанд тухай бүр хүргүүлж ажилласан. SMS sender програмын тусламжтайгаар иргэд аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нэг дор 5000 хүртэл хэрэглэгчид багц мессежийг хүргэх боломж бүрдсэн нь цаг агаараас үүдэлтэй учруулж болох эрсдэлийг түргэн шуурхай хүргэж ажилласанаар өмнөх онтой харьцуулахад 6,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлыг хангуулах		Аймгийн Засаг даргын А/503 дугаар захирамж, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Гамшгаас хамгаалах ангийн сургалтын төлөвлөгөөний дагуу гамшгаас хамгаалах Команд штабын сургуулийг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Жаргалтхаан суманд зохион байгууллаа. Сумын Онцгой комиссын бүрэлдэхүүний штабын дадлага сургуулийг 11:00 цагт эхлүүлж 1 дүгээр цагийн байдал "Коронавирус" Ковид-19 цар тахал, 2 дугаар цагийн байдал "Хээрийн түймэр", 3 дугаар цагийн байдал Мал амьтны гоц халдварт "Шүлхий" өвчний цагийн байдал дээр Астрономын 12 цаг, Оперативын 192 цаг дээр зохион байгуулсан. Цаг агаарын аюулт болон сэрэмжлүүлэг мэдээллийг сумдад албан тоотоор, цахим хуудсанд тухай бүр байршуулж урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажилласнаар гамшиг ослын дуудлагыг өмнөх онтой харьцуулахад 20,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	100%
67		7.2.1. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архидан донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлж, архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлж "Архидалтгүй Хэтийн Хэнтий" арга хэмжээг зохион байгуулна.	2021 - 2025	-	Эмийн болон албадан эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Аймгийн нэгдсэн эмнэлэг болон "Өндөрхаан Оршихуй" ХХК-ны сэтгэцийн эмнэлэгтэй хамтран 25 хүнийг эмийн эмчилгээнд хамруулаад байна.	10 хувь буюу 5 хүнийг эмийн болон албадан эмчилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.		Архидалтгүй хэтийн Хэнтий арга хэмжээний төлөвлөгөөг батлан 100 хувь хэрэгжүүлж ажиллаа. "Хэрлэнгийн цэнхэр алс" ТББ, "Өндөрхаан Оршихуй" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 25 хүнийг эмийн эмчилгээнд, Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаарх сургалт сурталчилгаанд 5242 иргэнийг хамруулсан байна.	100%

68	7.2. Хүн, нийгмийн амар тайван байдал	7.2.2. Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	2021 - 2025	-	Хамрагдсан иргэдийн тоогоор	Гэр бүлийн боловсрол олгох 17 удаагийн сургалт, 6 удаагийн подкастаар дамжуулан нийт 23.593 хүн хамруулсан. Мөн гэр бүлийн чиглэлээр 7 удаагийн нөлөөллийн ажил зохион байгуулж 4654 хүн 37 гэр бүл хамруулсан. Дээрх сургалт, нөлөөллийн ажлаар дамжуулан нийт хүн амын 33 хувь буюу 28.247 иргэн, 37 гэр бүлийг хамруулсан байна.	Урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа 6 удаа зохион байгуулж, нийт иргэдийн 20 хувийг сургалтад хамруулна.		"Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг 103 удаа зохион байгуулж нийт 24.648 хүнд хүрч нийт хүн амын 31.2 хувьд хүрч ажилласан байна. Мөн Тэмүүжи цогцолбор сургуулийн 1 дүгээр байрны урд талын авто замд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулан ажилласан. "	100%
69		7.3.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтыг нэмэгдүүлж, төв магистрал зам дагуу тээврийн хэрэгслийн бүртгэлжилт хурдны дундаж тодорхойлох хяналтын камер байрлуулан нэгдсэн системд холбож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.	2021 - 2025	-	Хяналтын камертай сумдын хувиар	Аймгийн 18 сумын 17 сум буюу 94 хувь нь дэвшилтэт технологи бүхий 322 хяналтын камертай болж иргэдийн амар тайван аюулгүй орчинд амьдрах болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүллээ.	Хяналтын камертай сумдын тоог нэмэгдүүлсэн байна		Хяналтын камергүй байсан Дадал суманд 2022 онд орон нутгийн төсвөөс 100 сая төгрөгөөр 13 цэгт хяналтын камер байрлуулснаар аймгийн 18 сум буюу бүх сум хяналтын камертай болсон байна. 2022 онд Чингис хотын нийт 139 камерт засвар үйлчилгээ хийлгэхээр орон нутгийн төсөвт 5 сая төгрөгийг суулгаж Авид хайрхан ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 139 камерт техникийн үзлэг хийж шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.	100%
70	7.3. Хууль сахиулах салбарын хөгжил	7.3.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулж, чадавхыг дээшлүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2025	-	Цогцос зөөвөрлөх чиргүүлтэй болсон байх	Шүүхийн шинжилгээний албанд 3.5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж "Цогцос зөөвөрлөх чиргүүл"-тэй болсноор албан хаагчдын ажиллах нөхцөл сайжирсан байна.	Шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмжөөр хангасан байна.		2022 оны 9 дүгээр сарын 14-ний А/496 захирамжаар 4 сая төгрөгийг шийдвэрлэн өгч шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж буюу дронтой болсон байна.	100%
71		7.3.3. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	2021 - 2025	-	Мал хулгайн гэмт хэргийн тоогоор	"Хяналт шалгалт" арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган 2021 оны 11 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 40 хоногийн хугацаатайгаар аймгийн хэмжээнд 9 хяналт шалгалтын байнгын болон хөдөлгөөнт пост ажиллаж байна. Мал хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7 хэргээр буюу 5.6 хувиар буурсан байна.	Хулгайн гэмт хэрэг дунджаас 3 хувь буурсан байна.		Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдаж буй "Мал мах-2022" нэгдсэн арга хэмжээний хүрээнд Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд "Хяналт шалгалт-2022" тусгай арга хэмжээг төлөвлөгөөг батлан зохион байгуулж байна. 3 жилийн дундажтай харьцуулахад ижил түвшинд байна.Өмчийн эсрэг хулгайлах гэмт хэргийг таслан зогсоох чиглэлээр нэгдсэн хяналт шалгалтын төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд өмчийн эсрэг хулгайлах гэмт хэрэг 360 болж суурь түвшинээс 7.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна	100%

72	8.1.1. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээг өргөтгөнө.	2021 - 2025	-	Ажлын гүйцэтгэлээр	Аялал жуулчлалын маршрутын дагуух сумдыг хатуу хучилттай авто замаар холбох ажлын хүрээнд Улсын төсвийн 45 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингис хотоос Дадал хүртэлх 270км хатуу хучилттай авто замын ажил Чингис хотоос 70 км /Бэрх тосгон хүртэл/ суурь асфальтан хучилт бүрэн хийгдсэн, ирэх онд үлдсэн замын өнгө давхаргын асфальт хучилт, хэвтээ тэмдэглэгээг хийгдэнэ. Бэрх тосгоноос Батноров чиглэл дэх замын буурь, суурь, шороон далангийн ажил хийгдэж эхлээд байна.	Чингис хот-Дадал чиглэлд хатуу хучилттай авто замын ажил үргэлжилнэ.		Чингис хот - Бэрх тосгон хүртэлх 70 км, Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын ажил дуусаж ашиглалтад оруулсан. Бэрх-Норовлин чиглэлийн 130 км, Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн 52.5 км тус тус хатуу хучилттай авто замын ажлууд хийгдэж дунджаар 35%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна. Үүнээс гадна Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто замын энэ жилийн төлөвлөгөөт ажил хэрэгжээд байна.	100%
73	8.1.2. Орон нутгийн болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд оруулах, мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий системийг аймгийн төв болон сумдад үе шаттайгаар байгуулна.	2021 - 2025	-	Цаг агаарын мэдээ хүргэсэн эсэх	2021 онд Байгаль, цаг уурын аюултай үзэгдэл болох /цасан болон шороон шуурга/ гэх мэт гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэрэмжлүүлэх багц мессеж мэдээг 30 удаа давхардсан тоогоор нийт 307689 иргэнд хүргэсэн ба цахим мэдээллийн хуудсаар дамжуулан 30 гаруй мянган хүнд цаг тухай бүр мэдээлэл хүргэж ажилласан.	цаг агаарын мэдээллийг тогтмол хүргэж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.		2022 онд Байгаль, цаг уурын аюултай үзэгдэл болох /цасан болон шороон шуурга/ гэх мэт гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэрэмжлүүлэх багц мессеж мэдээг 30 удаа давхардсан тоогоор нийт ..... иргэнд хүргэсэн ба цахим мэдээллийн хуудсаар дамжуулан 30 гаруй мянган хүнд цаг тухай бүр мэдээлэл хүргэж ажилласан.	100%
74	8.1.3. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн үйлчилгээг жигдрүүлнэ.	2021 - 2025	-	Ажлын гүйцэтгэлээр	""Дэлүүнболдог"" нисэх буудлын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25%-тай байна. ""Өндөрхаан"" нисэх буудлын хөөрч буух зурвасын ажлын гүйцэтгэл 75%-тай байна. ""Өндөрхаан"" нисэх буудлын барилга угсралтын ажил эхлээгүй. Норовлин, Биндэр, Галшар сумдад агаарын хөлөг хөөрч буух зурвасыг тогтоож хамгаалалтад авсан. Агаарын тээврийн дэд бүтэц бүрэн шийдэгдээгүй байгаа тул одоогийн байдлаар хуваарьт нислэг үйлдээгүй байна. Захиалгат нислэг үйлдэж байна."	"Дэлүүн болдог", "Өндөрхаан" нисэх буудлын барилгын ажил дуусна.		Өндөрхаан нисэх буудал"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 25%, "Дэлүүн Болдог нисэх буудал"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40%-тай үргэлжилж байна.Норовлин, Биндэр, Галшар сумдад агаарын хөлөг хөөрч буух зурвасыг тогтоож хамгаалалтад авсан.	30%



75		8.1.4. Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл төвлөрсөн зарим сумдын төвүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, давуу талд тулгуурлан бүсчилж хөгжүүлнэ.	2021 - 2025	-	Хөрөнгө оруулалтын хэмжээгээр	2021 онд Аймгийн хөрөнгө оруулалтаар түүхэн аялал жуулчлалын бүс болсон сумын төвүүдэд нийт 970.8 сая төгрөгийн санхүүжилт олгож өмнөх оноос 212.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.	Сумдын төвүүдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна.		2022 онд аялал жуулчлалын 3-н цогцолборын барилгад 4 нэмэлт гэрээ байгуулж ажил үргэлжилж байна. Үүнээс "Монголын нууц товчоо" цогцолборын гадна цахилгааны ажлыг ашиглалтад оруулсан. Мөн Баян-Овоо суманд мах төхөөрөх үйлдвэрийн барилгаын явц 50%-тай үргэлжилж байна.	100%
76	8.1. Дэд бүтэц	8.1.5. Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, шуудан үйлчилгээний хүрээг тэлж, чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021 - 2025	-	Орон нутгийн зорчигч тээврийн замнал нэмэгдсэн.	"2021 оны 10-р сарын 01-ний өдрөөс Хэнтий-Улаанбаатар чиглэлд өдөрт нэг удаа зорчигч тээврийн үйлчилгээ хийж байна. Дархан, Баянмөнх, Өмнөдэлгэр сумдад орон нутгийн зорчигч тээврийн замнал нэмэгдсэн. Тухайн замналуудад ""Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага"" MNS4598 стандартыг мөрдүүлснээр зорчигчдын аюулгүй, тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдэж байна."	Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээврийн хамрах хүрээг өргөтгөнө.		Улаанбаатар-Батноров-Улаанбаатар чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг 2022 оны 5 сараас эхлүүлэн 7 хоготг нэг удаа зохион байгуулж байна. Улаанбаатар-Бор-Өндөр-Улаанбаатар чиглэлийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг явуулах аж ахуйн нэгжийг судалж байна.	100%
77		8.1.6. Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, интернэт, IPTV хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	Шилэн кабел холбогдсон сум тосгодын тоогоор	2021 онд Хэрлэнбаян Улаан, Гурванбаян тосгоныг шилэн кабельд холбож өнөөдрийн байдлаар 18 сум 4 тосгон шилэн кабельд холбогдоод байна. Мөн аймгийн шилэн кабелийн урт өмнөх оноос 100 км-ээр нэмэгдэж 1210 км урт болсон.	Шилэн кабелийн хамрах хүрээг өргөтгөнө		"Бүх нийтийн үүргийн сан"-ийн хөрөнгө оруулалтаар Тахилгат тосгон G Mobile сүлжээнд хамрагдсан. Хэрлэнбаян-Улаан Гурванбаян тосгоныг шилэн кабельд холбосон. Үүрэн холбооны Unitel Group Чингис хотын гэр хорооллын 60%-ийг шилэн кабельд холбосон. Алслагдсан 5 сумын 5 багт шинээр 4G сүлжээг бүрэн нэвтрүүлсэн.	100%

78	8.1.7. Аймгийн хэмжээнд хаягжуулалт, газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	2021 - 2025	-	-	" 18 сум, 4 тосгоны нэгж талбар болон барилгын хаягийг засварлах орц гарц тэмдэглэх мөн шинээр хаяг олгох ажил хийгдсэн. Үүнд: Хаягийн засвар хийсэн болон орц гарц тэмдэглэсэн 2642 барилга, 2642 нэгж талбар, 1769 гудамж хаягийн мэдээллийн санд оруулсан. Хот суурин газрын суурьшлын бүсийн гудамжийг хаягийн мэдээллийн системд замын давхаргатай холбох ажлыг Хэрлэн сумын хэмжээнд 252 гудамж, 10575 нэгж талбар, 3000 орц гарцыг тэмдэглэж замчлалын системийн замыг мэдээллийн системд оруулж гудамжтай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн хаягийн тэмдгийг газарт суурилуулах ажлын хүрээнд 2021 онд Батширээт сум хаягийн тэмдэг суурилуулах ажлын зардалд 18.6 сая төгрөгийг сумын төсөвт тусгуулсан бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэхээр "Ньюхэйд лайн" ХХК-тай гэрээ байгуулж ажил хийгдэж байна."	-		Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг стандартын дагуу хаягжуулах ажлын хүрээнд Батширээт сум орон нутгийн хөгжлийн санд 18.4 сая төгрөгийг тусгуулж "Нью хэйд лайн" ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна. Жаргалтхаан сум 20 сая, Мөрөн сум 10 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд тусгуулан хаягжуулалтын ажлыг хийх, хаягийн тэмдгийг газарт суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахаар ажиллаж байна. Газар зүйн нэрийн тодруулга хийх, газар зүйн нэрийн мэдээллийн сан байгуулах ажлын хүрээнд 2022 онд Дадал, Өмнөдэлгэр сумд орон нутгийн хөгжлийн санд тус бүр 19 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулахаар ажиллаж байна.	70%
79	8.1.8. Бүсийн аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдийн уялдаа холбоог хангаж, хамтын ажиллагааг дэмжинэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	2021 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Дорноговь аймгийн Сайншанд хотод Зүүн болон төвийн бүсийн аймгуудын бизнес эрхлэгчид, худалдаа аж үйлвэрийн танхимын гишүүдын дунд "Бизнесийн салбарын хүний эрхийг хангах нь" сэдэвт зөвлөгөөн зохион байгуулагдаж бизнесийн орчны хүндрэл бэрхшээл, ажилчид, захирал харилцаа, хүний эрхийг хэрхэн хангах талаар хэлэлцүүлэг болсон.	бүсийн аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагаа сайжирсан байна.		Зүүн бүсийн "Экспортын чиг хандлага", "Бүтээгдэхүүний патент хөгжүүлэлт", "патентын эрх авах, сав баглаа" сэдвээр сургалт хийсэн. 20 аж ахуй нэгж сургалт зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаанд оролцож өөрийн бүтээгдэхүүнээ түгээн дэлгэрүүлэх, хөрш зэргэлдээ аймгуудын брэнд бүтээгдэхүүнүүдээс туршлага солилцох, брэнд бүтээгдэхүүний төрөл, патентын эрх авах үе шатууд болон өөрийн бүтээгдэхүүний дутагдалтай болон давуу талуудыг мэдэж авах, түүнийг засаж сайжруулах арга замыг олж авсан. Хамтын баталгаажуулалтын байгууллага МҮХАҮТХэнтий аймаг дахь салбарт байгуулсан.	100%

80	8.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	жуулчдын тоо өссөн эсэх	Аялал жуулчлалын технологийн дэвшил, цахим орчны гадаад дотоод сурталчилгааг нэмэгдүүлэх зорилгоор гар утасны хөтөч аппликейшнийг Англи, Монгол хэл дээр ашиглалтад оруулж хэрэглэгч, ашиглагчийн тоог нэмэгдүүлнэ. 2021 онд дотоодын жуулчдын тоо 53,7 мянгад хүрч өмнөх оноос 10 хувиар өссөн. Цар тахлын улмаас гадаад жуулчид өсөөгүй.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим орчинд сурталчилж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.		Хэнтий аймгийн аялал жуулчлал, түүх соёл, зан заншил, онцлог давуу талуудыг иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах, цахим орчинд гадаад дотоод сурталчилгааг нэмэгдүүлэх зорилготой "Khentii guide" гар утасны аппликейшний бар кодыг үйлчилгээний төв болон тээврийн хэрэгслүүд, зочид буудал, зоогийн газруудад болон цахимаар сурталчлан хандалтын тоог 150-аар нэмэгдүүлэн ажиллаж байна. Мөн аймаг орон нутгаа сурталчлах, таниулах зорилгоор "Хэнтий аймагт тавтай морил сэтгүүл"-ийн мэдээллийг шинэчилж 1000 ширхэг, Аялалын газрын зургийг 1500 ширхэгийг шинээр хэвлүүлээд байна. 2022 онд дотоодын жуулчид 54.8 мянга, гадаадын жуулчид 719 болж нэмэгдсэн нь өмнөх оноос дотоод жуулчдын тоо 12.7 хувь болж өссөн байна.	100%
81	8.2.2. "Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор" байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр /автозам, эрчим хүч, инженерийн шугам сүлжээ/ холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлийн хувиар	"Шихихутаг-Их засаг" цогцолборын барилгын ажлын явц 70 хувь, "Монголын нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолборын барилгын ажил 50 хувь, "Их Хуралдай" цогцолборын ажлын явц 90 хувь, "Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв"-ийн 2021 онд гүйцэтгэх ажил 90 хувь, Дадал сум "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолборын ажил 30 хувь, Батноров сумын "Тэнгэрийн андгай" цогцолборын хөшөө дурсгалын ажил 90 хувьтай хийгдээд байгаа ба 6 цогцолборын гүйцэтгэл дунджаар 70 хувьтай байна.	"Мянганы суут хүн Чингис хаан" цогцолборуудын ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж, гүйцэтгэлийг 80% хүргэнэ.		"Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн хүрээнд баригдаж буй цогцолборуудын ажлын явц 77 хувьтай үргэлжилж байна. Биндэр суманд баригдаж буй Их хуралдай цогцолборын гадна болон интерьерийн ажил дууссан. ""Шихихутаг-Их засаг" цогцолборын Барилга угсралтын ажил 70%, гадна инженерийн шугам сүлжээний ажил 100%, гадна тохижилт 50%, дотор интерьерийн ажил 20%-тай тус тус үргэлжилж байна. "Монголын нууц товчоо" цогцолборын Барилга угсралтын ажил 60%-тай цогцолборын гадна цахилгаан хангамжийн ажлыг "АЭБОО" ХХК гүйцэтгэж ажил 70%-тай хэвийн үргэлжилж байна. Мөн цогцолборын интерьер, гадна шугам сүлжээний ажлын гүйцэтгэгчээр "Ди Эс Ти" ХХК шалгарч 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулан барилгын ажлыг хийж байна. Түүхэн цогцолборуудыг ашиглалтанд оруулах бэлтгэл ажлыг хангаж, дэд бүтцэд холбох ажлууд хийгдэж байгаа бөгөөд холбогдох газруудтай хамтран тогтмол хяналт тавьж ажиллаж байна."	96%

82	8.2. Аялал жуулчлал	8.2.3. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хэнтий аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	хэрэгжилтээр	Төслийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн 15 арга хэмжээний 9 нь тодорхой шатандаа хэрэгжиж эхлээд байна.	төлөвлөгөөний дагуу төсөл үргэлжилнэ	Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд Дадал суманд баригдах Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын Мэдээллийн төвийн зураг төсөл, барилга угсралт, бараа нийлүүлэх ажил гүйцэтгэх тендерт шалгарсан "Мандалт Констракшн" компанитай гэрээ байгуулж, "Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор"-ын бүтээн байгуулалтыг 2 үе шаттайгаар 2023 оноос эхлүүлэхээр боллоо. Мөн хатуу хог хаягдлын 2-р зэргийн ландшафт байгууламж байгуулагдаж, гүйцэтгэл 72 хувьтай үргэлжилж байна. Сумын төвийн хатуу хучилттай 3.5 км авто зам дагуух 43 айлын хашаа, хогийн цэг байрлуулах ажил, баруун урд хотонд хүүхэд залуучуудын тоглоомын талбай, гудамжны талбай тэгшлэх ажлыг Цагаан булаг ХХК, Мянган эргэлт ХХК-тай гэрээ байгуулж хийж гүйцэтгэлээ. Мөн сумын төв зам дагуу 3 байрлалд түр хогийн цэг байрлуулах ажлыг Буянт Дадал ХХК хийж гүйцэтгэлээ. Уг хогийн цэг нь хогийг цаасны, хуванцар, шил лаазны, бусад хаягдал гэж ангилан ялгах ба тус бүр 1м.куб-ын багтаамжтай юм. Ингэснээр түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд сумын ИТХ-аар батлагдсан жишиг хашааны стандартыг айл өрхүүдэд хүргэх олон янзын хашааг нэг стандартад оруулах, хогоо ангилан ялгахад сургахаас гадна цаашид стандарт мөрдүүлэх зорилготой юм. Төслийн хүрээнд	90%
----	---------------------	--	-------------	---	--------------	---	--------------------------------------	--	-----

83	8.2.4. Орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг шинээр бий болгож, хөгжүүлнэ.	2021 - 2025	-	шинээр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний тоогоор	Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх чиглэлийг хүргүүлж, дэмжиж ажилласнаар 2 суманд 2 жуулчны баазыг түшиглэн 3 шинэ төрөлжсөн аялалын бүтээгдэхүүн бий болголоо.	1-ээс доошгүй төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгосон байна.		"Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож хөгжүүлэх зорилгоор Биндэр сумын Чингисийн тоонот жуулчны бааз ""Тогорууны баяр"" шувуу ажиглах тусгай аяллыг зохион байгуулж байна. "Эзэн Чингис хааны өлгий нутгаар 100 км" сэдвийн дор Хэнтий аймаг дахь явган алхалтын холбоотой хамтран түүх соёлын дурсгалт газруудаар дамжин Өндөрхаан хайрханруу аялах алхалтын маршрут чиглэлийг гаргаж тусгай аялал 1 удаа зохион байгуулж, 8 аймаг, 9 дүүргийн 70 орчим алхагчдыг хамрууллаа. Мөн Дадал суманд Эзэн Чингис хааны мэндэлсэн өдрийг тохиолдуулан ""Монгол бахархлын өдөр"" өвлийн эвент арга хэмжээг зохион байгууллаа. Цаашид аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, жил бүр зохион байгуулахаар төлөвлөөд байна. "	100%
84	8.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	2021 онд засгийн газраас 556.8 кг хүнсний ногооны үрийг 80% хөнгөлөлттэй өгсөн. Мөн хаврын улиралд шаардлагатай 33 тн махны нөөцийн үнийн урамшуулал олгож Мах 100%, төмс 100%, хүнсний ногоог 62%-г дотоодоос хангаж байна.	Мах 100%, төмс 100%, хүнсний ногооны дотоодоос хангах хэмжээг нэмэгдүүлнэ.		2022 онд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээ Мах 100%, төмс 100%, хүнсний ногоо 34.6%, сүү 100%, гурилан бүтээгдэхүүн 32.6%, өндөг 49.3%, жимс, жимсгэнэ 30.1%, ундны ус 35.0% -иар дотоодын хэрэгцээг тус тус хангасан. Хэнтий аймгийн "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны "Хүнсний хангамжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 03 дугаар тогтоол гаргуулан, 5 жилийн төлөвлөгөө боловсруулан ажилласан. Хүнсний хангамжийг сайжруулах 5 жилийн зорилт мах махан бүтээгдэхүүн 100%, сүү сүүн бүтээгдэхүүн 100%, төмс 100%, хүнсний ногоо 100%, өндөг 54%, гурил 20%, гурилан бүтээгдэхүүн 37%, жимс жимсгэнэ 35%, ус 40% хангахаар ажиллана.	100%

85	8.3.2. Аймгийн махны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Монамит мийт ХХК- н Хятад улсруу ямааны мах экспортлох санал хүргүүлсэн боловч Ковид-19 халдварын улмаас хойшлогдсон. "Өвлийн идэш-2021" арга хэмжээнд Баян-Адарга, Баянмөнх, Баянхутаг, Батширээт, Биндэр, Дадал, Дархан, Дэлгэрхаан, Өмнөдэлгэр, Хэрлэн сумдын малчид, жижиг дунд үйлдвэрлэгчид болон "Мон мийт" ХХК, "Өгөөмөр" ХХК, Дадал сумын "Аз хулан" ХХК-ууд оролцсон. Хэнтий аймгийн борлуулалт 2021 оны 11 сарын 25 наас 12 сарын 03-ний байдлаар: Мах: Үхрийн мах 46.4 тн, Адууны мах 7.7 тн, Хонины мах 21.1 тн, Ямааны мах 5.7 тн, нийт 80.9 тн-ыг тус тус борлуулж 662.8 сая төгрөг орлого олсон.	Махны экспортын хэмжээ нэмэгдсэн байна.		Монамит мийт ХХК- н Хятад улсруу ямааны мах экспортлох санал хүргүүлсэн боловч Ковид-19 халдварын улмаас хойшлогдсон. Мөн аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд 2022 оны хаврын улиралд 60 тн мах, 6 аж ахуйн нэгж 623 тн мах нөөцөлж бэлтгэл ажлыг хангаж ажилласан.	100%
86	8.3.3. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана.	2021 - 2025	-	тоогоор	Зах зээл ба бэлчээрийн удирлага төсөлтэй хамтран малчдын оролцоотойгоор 574,5 сая төгрөгийн хөрөнгөөр 15 суманд 49 инженерийн хийцтэй худаг шинээр гаргаж, 73,5 мянган га бэлчээрийн талбайг усжуулсан.	28-аас багагүй худаг шинээр гаргана.		"Энэ онд 8 суманд орон нутгийн төсвийн 347.0 сая төгрөгийн хөрөнгөөр 20 худаг, 14 суманд малчдын 340.0 сая төгрөгийн хөрөнгөөр 34 худаг, төсөл хөтөлбөрийн 192,0 сая төгрөгийн санхүүжилтээр 6 худаг, нийт 60 гүн өрмийн худаг шинээр гаргаж, 90.0 мянган га бэлчээрийг усжуулсан. ОНТөсвийн 9.0 сая төгрөгийн хөрөнгөөр Жаргалтаан суманд 2 худаг сэргээн засварласан. Малыг тоо толгой албан татварын 37.0 сая төгрөгийн хөрөнгөөр Дадал, Батноров, Хэрлэн суманд 10 сая төгрөгийн санхүүжилтээр 5 булгийн эхийг хашиж хамгаалсан. Мөрөн сум цөөрөм байгуулах ажлын зураг төсвийг 30 сая төгрөгөөр гүйцэтгэсэн."	100%

<p>8.3.4. Малын чанар, ашиг шим, үүлдэр угсааг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж, малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуйн салбарыг идэвхжүүлнэ.</p>	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	<p>Галшарын улаан ямаа өмнөх оноос 1500 нэмэгдэж 4000 болсон. 2000 мах сүүний хосолмол ашиг шимтэй Дадал үхэр, 1600 галшар үүлдрийн адуунд үзлэг ангилалт хийсэн. 2021 онд анх удаа 21.0 мянган толгой бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийж, 18753 буюу 88,3%-ыг цөм болон үржлийн сүрэгт бүртгэсэн. Мөн 25 өрхийн 400 хонь, 7 гүү, 440 үнээ, нийт 847 малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийсэн.</p>	-		<p>Улсын Их Хурлын 82 дугаар тогтоолоор батлагдсан "Малын генетик нөөцийн тухай хууль", аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 32.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 сумын 55 багийн 101 өрхийн 16004 толгой хуц, 9291 толгой ухна, нийт 25295 толгой бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтанд хамруулж, 6.9 мянган толгой буюу 27.4 хувийг цөм сүрэгт, 15.4 мянган толгой буюу 61.0 хувийг үржлийн сүрэгт, 2.9 мянган толгой буюу 11.6 хувийг хэрэгцээний сүрэгт тус тус бүртгэсэн. Европын холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах нь "Stream" төсөл болон "Өндөрхаан-Үржил" хоршоо нь Норовлин, Жаргалтхаан, Хэрлэн, Баян-Адарга, Өмнөдэлгэр, Биндэр сумдын 4 аж ахуйн нэгж, 53 өрхийн 879 толгой үнээнд Ангус, Геррефорд, Лимузин үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр, 100 толгой хонинд ноосны чиглэлийн Орхон үүлдрийн хуцны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийж, малын чанарыг сайжруулах арга хэмжээ авч ажилласан.</p>	100%
---	-------------	---	--------------	--	---	--	---	------

88	8.3. Төлөөрийн хөдөө аж ахуй	8.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, малаас хүнд дамжих халдварт болон гоц халдварт өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаална.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр,эрүүл ахуйн шаардлагыг хангаж нийт 129 удаагийн 379 дээжийг авч холбогдох стандартын дагуу мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээ хийхэд стандартын шаардлага хангаагүй бүтээгдэхүүн илрээгүй. Аймгийн хэмжээнд хорогдсон 34,2 мянган малыг 99,8 хувьтай сэг зэм устгах ажлыг зохион байгуулж, нийт 524,9 мянган м2 талбайг халдваргүйтгэсэн. оломтлон гардаг 5 төрлийн халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт дундажаар 96.8%-тай хийгдсэн ба 15 сумын 106 голомтын цэгийн 106.7 мянган м2 талбайг зориулалтын ариутгалын бодисоор халдваргүйтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад халдварт өвчний гаралт 51.6%-р буурсан.	Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангагдаж, алварт өвчний гаралт буурсан байна.		6 суманд зөөврийн компьютер, бар код уншигч, хэвлэгч төхөөрөмж, мал тарилгын хашааны зардлыг шийдвэрлэсэн. 4 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт 97.6 %-тай хийгдэж байна. Малаас хүнд халдварладаг галзуу, боом болон шүлхий, бог малын мялзан, хонины цэцэг өвчний нийт 85 голомтыг халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэсэн. Халдварт өвчний гаралт өмнөх жилээс 28.6 хувь буурсан байна.	100%
89		8.3.6. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Нийт тариалангийн талбайн эргэлт 32,1 мянган га болж, төмс, хүнсний ногоогоор дотоодын хэрэгцээний 74 хувийг хангаж байна. Мөн жимс жимсгэний тариалалт 33,1 га-аас 47,4 а болж нэмэгдэн, ургац хураалт 15 тн-оос 19 тн болж нэмэгдсэн байна. Малын тэжээл тариалалтын талбай өмнөх оноос 6373 га-аар нэмэгдэж 7773 га болж, хураан авсан ногоон тэжээлийн хэмжээ 20.2 мяган тонн болж өссөн.	Тариалангийн талбайн эргэлтийг нэмэгдүүлж, голлох нэр төрлийн тарималаар дотоодын хэрэгцээг хангаж, ашигт тарималын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.		2022 онд атаршсан 5140 га талбайг шинээр эргэлтэд оруулсан. Хүнсний ногоо 271,5 га-д тариалалт хийж, 3317 тн ургац хураан авч өмнөх оны тариалалтаас 36.6 га-р нэмэгдүүлж хүн амын хэрэгцээний 44,5 хувийг хангаж ажилласан.	100%



90	8.3.7. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлж, малчдын орлогыг өсгөж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хэрлэн суманд ноос угаах үйлдвэр шинээр ашиглалтанд орж Сүхбаатар, Хэнтий аймгийн малчдаас 800 тн ноос худалдан авч, анхан шатны боловсруулалт хийж угаан 70-80 иргэнийг түр ажлын байраар ханган ажилласан.	малын гаралтай түүхий эд боловсруулах үйлвэр байгуулна.		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Жаргалтхаан суманд "Хаан хүнс" ХХК-ны 100 хувийн хөрөнгө оруулалттай, 6.2 тэрбум төгрөгийн өртөг бүхий мах боловсруулах үйлдвэр шинээр баригдаж байна. Барилгын гүйцэтгэл 70 хувьтай байна. Тухайн үйлдвэр ашиглалтад орсноор малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум орон нутагтаа 100 хувь худалдан борлуулах боломж бүрдэнэ. Мөн Баян-Овоо суманд "Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил" төслийн 750.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Мал төхөөрөх цогцолбор"-ыг шинээр барьж хоршоонд хариуцуулан ажиллаж байна. Мөрөн, Биндэр сумдад европын холбооны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй "Хөдөө орон нутгийн эдийн засгийн хөгжилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах нь-ИМПАКТ"- төслийн 100 хувийн санхүүжилтээр түүхий эдийн агуулах шинээр барьж Биндэр сумын "Өгөөж баян Биндэрьяа", Мөрөн сумын "Мөнх мандах Мөрөн" хоршоонд тус тус хүлээлгэн өгсөн	100%
91	8.3.8. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтийн шинэ боломжийг нэвтрүүлж, оновчтой хуваарилж, бизнес инкубатор төвөөр бойжуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэн, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Дадал, Батноров, Баян-Адарга, Хэрлэн, Батширээт, Дархан сумдын сум хөгжүүлэх сангаас 4 аж ахуйн нэгж, 42 иргэнд 545.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, 61 ажлын байрыг хадгалж, 108 ажлын байрыг шинээр бий болгосон. Мөн Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс 2 аж ахуйн нэгж, 34 иргэнд 373 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Бизнес инкубатор төвд 1 хүнсний ногоо боловсруулах цехийг бойжуулан гаргаж, мужаан, нарийн боов үйлдвэрлэгч 2 аж ахуйн нэгжийг шинээр оруулснаар нийт 7 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, 2 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна.	ЖДҮ, бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн боломж нээгдэж, бизнес инкубаторын үйл ажиллагаа сайжирсан байна.		Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 4 аж ахуй нэгжид 470 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгосон. Дадал, Хэрлэн, Өмнөдэлгэр зэрэг сумдад Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 683 сая төгрөгийн санхүүжилтийг 6 хоршоо, 9 аж ахуй нэгж, 10 иргэнд олгож 84 ажлын байр хадгалагдан үлдэж, 112 ажлын байрыг шинээр бий болгосон. Мөн Хөгжлийн шийдэл Бест хөтөлбөрөөс гарааны биенес эрхлэгч 4 иргэн аж ахуй нэгжид 40.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. Бизнес Инкубатор төвд 6 аж ахуй бойжиж үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.	100%

92	8.3. Тогтвортой хөдөө аж ахуй	8.3.9. Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг өсгөнө.	2021 - 2025	-	гүйцэтгэлээр	Хэрлэн суманд 700 га талбайн услалтын систем шинээр барих зураг төслийн ажил хийгдэж, тендер зарлагдан ирэх онд барих ажил эхэлнэ.	Услалтын систетийн ажил 10 хувиар нэмэгдсэн байна.	"Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 100 хувийн санхүүжилтээр Хэрлэн суманд 700 га-д услалтын систем шинээр байгуулах зураг төслийн ажил хийгдэж хашаажуулалт болон толгойн барилгын ажил эхлээд 30 гаруй хувийн хэзэгжилттэй байна.	100%
Үнэлгээний дундаж									95.15%